

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ӨМА-2024/37-15-ШТА-ГА

ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГ БОЛОВСРУУЛАХ, ЗАРЦУУЛАХ, БҮРТГЭХ, ТАЙЛАГНАХ,
ХЯНАЛТ ТАВИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Даланзадгад хот 2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлал.....	2
Хүснэгтийн жагсаалт.....	2
Дүрслэлийн жагсаалт.....	2
Хавсралтын жагсаалт.....	3
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	5

БҮЛЭГ 1. ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ОНОВЧГҮЙ, ХҮРЭХ ҮР ДҮНГ ЕРӨНХИЙ БАЙДЛААР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА..... 8

А.1 Холбогдох хууль, тогтоомжид заасан төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөж байх шаардлагатай байна..... 8

А.2 Шалгуур үзүүлэлт оновчгүй, хүрэх үр дүнг хэт ерөнхий төлөвлөсөн нь хөтөлбөрүүдийн үр дүнг бууруулж байна..... 9

БҮЛЭГ 2. ХӨТӨЛБӨРИЙН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТ БУСААР, ЗОРИЛГО, ЗОРИЛТОД НИЙЦЭХГҮЙ, ҮР ДҮНГҮЙ ЗАРЦУУЛСАН НЬ УДИРДАХ БОЛОН ХЯНАЛТ ХИЙХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ХЯНАЛТ СУЛ БАЙГААГ ХАРУУЛЖ БАЙНА..... 10

Б.1 Хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцдоггүй, нэгдсэн судалгаа, мэдээллийн сан байхгүй, өмнөх онуудын баримт материалыг архивын нэгж үүсгээгүй нь хөтөлбөрийн үр дүнг бууруулж байна..... 10

Б.2 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнд тавих хяналт хангалтгүй байна..... 51

ДҮГНЭЛТ..... 54

ЗӨВЛӨМЖ..... 56

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ..... 57

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ШТА	Шууд тайлагнах аудит
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХАА	Худалдан авах ажиллагаа
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ЗҮГСЖ	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНТХ	Орон нутгийн төсвийн хөрөнгө

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	<i>Батлагдсан төсөл, хөтөлбөрийн жагсаалт</i>	6
Хүснэгт 2	<i>Хөтөлбөрүүдийг дэвшүүлсэн зорилтоор ангилсан байдал</i>	8
Хүснэгт 3	<i>Хөтөлбөр, ТАХ-ны батлагдсан төсөв</i>	8
Хүснэгт 4	<i>Хөтөлбөрүүдийн батлагдсан төсөв, гүйцэтгэл</i>	9
Хүснэгт 5	<i>"Шинэ мянган айл" орон сууцны хөтөлбөрийн санхүүжилт</i>	10
Хүснэгт 6	<i>"Шинэ мянган айл" хөтөлбөрт хамрагдсан өрх, зорилтот бүлгээр</i>	16
Хүснэгт 7	<i>"Эрүүл элэг" хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан төсөв</i>	17
Хүснэгт 8	<i>"Эрүүл элэг" хөтөлбөрийн хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан, эмчлүүлсэн иргэдийн статистик</i>	17
Хүснэгт 9	<i>"Нутгийн дэм" хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан төсөв</i>	18
Хүснэгт 10	<i>"Агаарын бохирдолгүй Өмнөговь" хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан төсөв</i>	19
Хүснэгт 11	<i>"Агаарын бохирдолгүй Өмнөговь" хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт</i>	20
Хүснэгт 12	<i>"Нээлттэй Өмнөговь" хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан төсөв.</i>	22
Хүснэгт 13	<i>"Залуус" хөтөлбөрт зарцуулсан төсөв</i>	23
Хүснэгт 14	<i>"Цэгцтэй гэр хороолол" хөтөлбөрт зарцуулсан төсөв</i>	24
Хүснэгт 15	<i>Нутгийн үйлдвэрлэгч хөтөлбөрийн баталсан төсөв, гүйцэтгэл.</i>	26
Хүснэгт 16	<i>Чинээлэг малчин хөтөлбөрт зарцуулсан гүйцэтгэл.</i>	27
Хүснэгт 17	<i>"Харшлын эсрэг" хөтөлбөрийн санхүүжилт.</i>	29
Хүснэгт 18	<i>"Эрүүл шүд" хөтөлбөрийн санхүүжилт.</i>	30
Хүснэгт 19	<i>"Хөгжлийн гүүр" хөтөлбөрийн санхүүжилт</i>	33
Хүснэгт 20	<i>"Хөгжлийн гүүр" хөтөлбөрийн хүрээнд хамрагдсан хүний тоо</i>	33
Хүснэгт 21	<i>"Хөгжлийн гүүр" хөтөлбөрийн хүрээнд хамрагдсан хүний тоо</i>	34
Хүснэгт 22	<i>"Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая" хөтөлбөрийн санхүүжилт</i>	35
Хүснэгт 23	<i>Оюутны тэтгэлэг" хөтөлбөрийн санхүүжилт.</i>	35
Хүснэгт 24	<i>Цахим Өмнөговь" хөтөлбөрийн санхүүжилт.</i>	36
Хүснэгт 25	<i>"Сурагч Солилцоо" хөтөлбөрийн санхүүжилт</i>	37

Хүснэгт 26	"Ээлтэй өмнөговь" хөтөлбөр Шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин.	40
Хүснэгт 27	"Эх хүүхдийн эрүүл мэнд" хөтөлбөр шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин (Зорилт 1)	42
Хүснэгт 28	"Эх хүүхдийн эрүүл мэнд" шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин (Зорилт 2)	42
Хүснэгт 29	"Өсөлтийг өрх бүрт" хөтөлбөрийн санхүүжилт. /сая төгрөг/	44
Хүснэгт 30	"Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" хөтөлбөр	45
Хүснэгт 31	Түр хамгаалах байрны хөтөлбөр, арга хэмжээ. /сая төгрөг/	46
Хүснэгт 32	"Чадварлаг багш" хөтөлбөрийн санхүүжилт.	47
Хүснэгт 33	"Сүү тараг" хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо.	48
Хүснэгт 34	Үндэсний болон бусад орон нутгийн онцлогтой спортыг хөгжүүлэх төсөл арга хэмжээ	49
Хүснэгт 35	Дэмжлэг үзүүлсэн спортын холбоо, клубүүд	49
Дүрслэл 1	Эко жорлон" хөтөлбөрийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гүйцэтгэл.	32
Дүрслэл 2	"Мөрөөдөлдөө хүрэх алхам-2" арга хэмжээнд хамрагдсан Даланзадгад сумын мэдээлэл.	38
Дүрслэл 3	Мөрөөдөлдөө хүрэх алхам-2" арга хэмжээнд хамрагдсан сумдын мэдээлэл	38
Дүрслэл 4	"Ээлтэй Өмнөговь" хөтөлбөрийн санхүүжилт	39
Дүрслэл 5	"Говийн ирээдүй хүүхэд" хөтөлбөрийн санхүүжилт.	41
Дүрслэл 6	Эх хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөрийн санхүүжилт.	41
Дүрслэл 7	Говь+Ус хөтөлбөрийн санхүүжилт	43
Дүрслэл 8	Эрдэмтэн судлаачдын чуулганы зарцуулалт	43
Дүрслэл 9	"Сүү тараг" хөтөлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэл	48

Хавсралт №1	Аймгийн Засаг даргын захирамжаар орон сууцны нөхцөлөө сайжруулах дэмжлэг авсан төрийн албан хаагчдын судалгаа /2021-2024 он/
Хавсралт №2	Аймгийн Засаг даргын захирамжаар эмчилгээний зардлын тусламж авсан төрийн албан хаагчдын судалгаа /2021-2024 он/
Хавсралт №3	Аймгийн Засаг даргын захирамжаар сургалтын төлбөрт дэмжлэг авсан төрийн албан хаагчдын судалгаа /2021-2024 он/
Хавсралт №4	"Чинээлэг малчин хөтөлбөрийн зардлаас сургалтын төлбөрийн дэмжлэг олгосон жагсаалт
Хавсралт №5	Арга хэмжээний зардлаас "Мандах" их сургуульд эчнээгээр суралцаж буй иргэдийн жагсаалт
Хавсралт №6	"Орон нутгийн хэрэгцээт боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор оюутан суралцагчдыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах" аргэ хэмжээний зардлаас гадаадын их дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудад олгосон тэтгэлгийн жагсаалт
Хавсралт №7	"Хөгжлийн гүүр" хөтөлбөрийн зорилттой нийцээгүй арга хэмжээний жагсаалт
Хавсралт №8	"Хөгжлийн гүүр" хөтөлбөрт хамрагдсан иргэдийн давхардсан байдлын судалгаа
Хавсралт №9	Арга хэмжээний санхүүжилтаар гадаад улсад сургалтад хамрагдсан албан хаагчдын мэдээлэл
Хавсралт №10	"Нутгийн үйлдвэрлэгч" хөтөлбөрийн санхүүжилтаар гадаад улсад аялсан иргэдийн жагсаалт
Хавсралт №11	Хөтөлбөрөөс санхүүгийн дэмжлэг олгосон жагсаалт
Хавсралт №12	Удам залгасан залуу малчин өрхөд гэр олгосон жагсаалт
Хавсралт №13	Мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний чанар хүртээмж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ

Хавсралт №14	Агаарын бохирдол бууруулах чиглэлээр зорилтод бүлгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах Монгол гэрийн дулаалгын багц олгосон иргэдийн мэдээлэл
Хавсралт №15	Гэрээ байгуулж зуух олгосон иргэдийн нэрс
Хавсралт №16	“Эко жорлон” хөтөлбөрт хамрагдсан айл өрхийн судалгаа
Хавсралт №17	“Чинээлэг малчин хөтөлбөр”-ийн зардлаас худалдан авсан хээлтүүлэгчийн судалгаа
Хавсралт №18	Ботгоны урамшуулал олгосон жагсаалт
Хавсралт №19	Сарлагны урамшуулал олгосон жагсаалт
Хавсралт №20	Даланзадгад сумын Сургууль, цэцэрлэгт суурилуулсан шүүлтүүр
Хавсралт №21	“Шинэ мянган айл”, “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт /2021-2024 он/

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/162 дугаар “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго

“ОНТХ-өөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төсөл, хөтөлбөр, арга хэмжээ нь төлөвлөлтийн шаардлагад нийцэж буй эсэх,
- Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн ИТХ, ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Боловсролын газар, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Байгаль орчны газар болон 2021-2024 онуудад ОНТХ-өөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, зарим арга хэмжээнд хамрагдсан байгууллага, хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан орон нутгийн бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухай асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэсэн.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам (Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолын хавсралт)
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам

- Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам
- Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал
- Аймгийн ИТХ-аас 2021-2024 онуудад баталсан тогтоолууд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, Ж.Болормаа, С.Одончимэг, аудитор Э.Жаргал, М.Номиндарь, Т.Будсүрэн, Ө.Болортуяа, Э.Жамцдорж, П.Санчиргарав, О.Чойдорж нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл:

Аудитыг гүйцэтгэх хугацаанд шалгагдагч байгууллагын албан хаагчид өмнөх онд хэрэгжүүлсэн ажлуудын баримт материалыг архивлаагүй, төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг үнэн зөв, бүрэн ирүүлэхгүй байсан.

Ерөнхий мэдээлэл:

Аймгийн ИТХ-ын 2020 оны 2/4 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан байна. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 6 бүлэг, 28 зорилт, 211 арга хэмжээг багтаасан байна. Өмнөговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор 2021 онд нийт 23 хөтөлбөр, 2023 он 1 хөтөлбөр, 2024 онд 1 хөтөлбөрийг нэмж баталсан байна.

Хүснэгт 1. Батлагдсан төсөл, хөтөлбөрийн жагсаалт

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	Баталсан тогтоолын		Хэрэгжүүлэх хугацаа
		Огноо	Дугаар	
1	Эрүүл шүд	2021.02.08	27	2021-2024
2	Говийн ирээдүй- Хүүхэд	2021.02.08	28	2021-2024
3	Ээлтэй Өмнөговь	2021.02.08	29	2021-2024
4	Чинээлэг малчин	2021.03.09	32	2020-2024
5	Говь+Ус	2021.03.09	33	2020-2024
6	Агаарын бохирдолгүй Өмнөговь	2021.03.26	47	2020-2024
7	Шинэ мянган айл	2021.03.26	49	2021-2025
8	Эрүүл элэг	2021.04.01	58	2021-2024
9	Чадварлаг багш	2021.04.01	59	2021-2024
10	Сурагч солилцоо	2021.04.01	60	2021-2024
11	Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая	2021.04.01	61	2021-2024
12	Өсөлтийг өрх бүрд	2021.04.01	62	2021-2024
13	Залуус	2021.04.01	63	2021-2024
14	Цахим Өмнөговь	2021.05.05	70	2021-2024
15	Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх	2021.05.05	71	2021-2024
16	Сүү тараг	2021.06.17	86	2021-2024
17	Харшлын эсрэг	2021.06.17	87	2021-2024
18	Эх хүүхдийн эрүүл мэнд	2021.06.17	88	2021-2024
19	Нутгийн дэм	2021.06.17	89	2021-2024
20	Цэгцтэй гэр хороолол	2021.06.17	90	2021-2024
21	Эко жорлон	2021.10.28	167	2020-2024
22	Нутгийн үйлдвэрлэгч	2021.12.22	198	2021-2024
23	Хөгжлийн гүүр	2021.12.22	202	2022-2024
24	Нээлттэй Өмнөговь	2023.03.27	10/1	2023-2024
25	Математик боловсролын хөгжил	2024.04.30	17/11	2024-2028

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолууд

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2023 оны тайланд 24 хөтөлбөрөөс 1 хөтөлбөр 100%-ийн биелэлттэй буюу “Үр дүнтэй”, 22 хөтөлбөр 70-99%-ийн биелэлттэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсэн, 1 хөтөлбөрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна. Харин “Математик боловсролын хөгжил” хөтөлбөрийг 2024 онд баталсан боловч хэрэгжүүлээгүй байна.

БҮЛЭГ 1. ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ОНОВЧГҮЙ, ХҮРЭХ ҮР ДҮНГ ЕРӨНХИЙ БАЙДЛААР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

А.1 Холбогдох хууль, тогтоомжид заасан төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөж байх шаардлагатай байна.

1.1 УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан байдаг. Тус хөгжлийн бодлого нь чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлэхэд чиглэгдсэн.

1.2 Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан арга хэмжээний хүрээд 2021 онд 23 хөтөлбөр, 2023 он 1 хөтөлбөр, 2024 онд 1 хөтөлбөр нийт 25 хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчийн тогтоолоор баталсан байна.

1.3 “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан аймагт 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан 24 хөтөлбөрийг зорилтоор нь ангилан харуулбал:

Хүснэгт 2. Хөтөлбөрүүдийг дэвшүүлсэн зорилтоор ангилсан байдал

№	Зорилт	Хөтөлбөрийн тоо	Эзлэх хувь
1	Хүний хөгжил	11	45.8
2	Амьдралын чанар ба дундаж давхарга	3	12.5
3	Амар тайван аюулгүй нийгэм	1	4.2
4	Эдийн засаг	3	12.5
5	Ногоон хөгжил	3	12.5
6	Бүсчилсэн хөгжил	2	8.3
7	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	0	0
8	Сайн засаглал	1	4.2
Нийт		24	100

Эх сурвалж: Гүйцэтгэлийн аудитын судалгаа №1

1.4 Дээрх хүснэгтээс харахад 2021-2024 онуудад хэрэгжсэн 24 хөтөлбөр “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилтуудыг хангахад чиглэсэн байна.

1.5 ОНТХ-өөр хэрэгжих хөтөлбөр, ТАХ-г аймгийн ИТХ жил бүр хэлэлцэн тогтоолын хавсралтаар нэр, хэрэгжих хугацаа, тухайн онд санхүүжих дүнг баталсан байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, ТАХ-ны батлагдсан төсөв

/сая.төгрөг/

№	Он	Аймгийн нийт орлого	Аймгийн нийт зарлага	Хөтөлбөр, ТАХ	
				Тоо	Дүн
1	2021	234,105.0	234,105.0	47	12,619.3
2	2022	478,395.2	478,395.2	63	41,188.2
3	2023	940,801.0	940,801.0	109	120,067.4
4	2024	2,091,928.2	2,091,928.2	112	107,850.3

Эх сурвалж: ИТХ-ын тогтоолууд

1.6 Төсвийн хөрөнгө хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, ТАХ-ний тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

1.7 Гэсэн хэдийн боловч эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүдийг эрэмбэлэн ТАХ-ний жагсаалтыг бэлтгэхээр заасан байдаг ч хууль, тогтоомжид

заасан шалгуур, нөхцөлийн дагуу төлөвлөөгүй, төлөвлөлтийн шатанд хэрэгжүүлсэн ажлын баримт материал байхгүй байна.

1.8 Өөрөөр хэлбэл төсөв боловсруулахдаа хуулийн дагуу төлөвлөдөггүй, түүнд тавих дотоод хяналт сул байгаагаас төлөвлөлтийн шаардлага хангагдахгүй батлагдаж байна.

1.9 Цаашид Төсвийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөн батлуулж байх шаардлагатай байна.

А.2 Шалгуур үзүүлэлт оновчгүй, хүрэх үр дүнг хэт ерөнхий төлөвлөсөн нь хөтөлбөрүүдийн үр дүнг бууруулж байна.

1.10 Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2¹-т төлөвлөлтийн баримт бичгийн талаар тодорхой заасан ч эдгээр хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлт оновчгүй, хүрэх үр дүнг хэт ерөнхий төлөвлөсөн нь хөтөлбөрүүдийн үр дүнг бууруулж байна.

1.11 Хөтөлбөрүүдийн он тус бүрд төлөвлөсөн санхүүжилт 150.0 - 57,489.9 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. ОНТХ-өөр хэрэгжүүлэхээр баталсан хөтөлбөрүүдийн санхүүжих дүнг эрэмбэлэн харуулбал:

Хүснэгт 4. Хөтөлбөрүүдийн батлагдсан төсөв, гүйцэтгэл

/сая.төгрөг/

№	Хөтөлбөрийн нэр	2021 он		2022 он		2023 он		2024 он III улирал		Нийт	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
1	Нутгийн дэм	1,650.0	1,438.4	1,635.0	1,441.8	23,554.9	19,603.2	30,650.0	17,950.2	57,489.9	40,433.6
2	Шинэ мянган айл	2,715.0	2,566.8	10,679.4	10,149.6	17,643.0	12,419.9	1,740.0	-	32,777.4	25,136.3
3	Нутгийн үйлдвэрлэгч	-	-	3,500.0	641.3	3,000.0	2,127.0	1,281.8	-	7,781.8	2,768.3
4	Агаарын бохирдолгүй Өмнөговь	-	-	1,256.2	399.9	4,580.0	3,004.8	600.0	-	6,436.2	3,404.7
5	Цэгцтэй гэр хороолол	-	-	1,458.0	483.8	3,450.9	2,575.8	912.0	389.8	5,820.9	3,449.4
6	Өсөлтийг өрх бүрд	1,000.0	618.5	1,000.0	974.6	1,600.0	1,591.0	2,000.0	1,012.0	5,600.0	4,196.1
7	Хөгжлийн гүүр	-	-	400.0	371.5	3,100.0	3,099.8	1,500.0	999.0	5,000.0	4,470.3
8	Говийн ирээдүй-Хүүхэд	180.0	168.3	300.0	299.1	4,025.7	4,025.7	450.0	444.8	4,955.7	4,937.9
9	Чинээлэг малчин	466.0	333.3	1,000.0	801.1	1,190.0	935.2	1,788.0	494.1	4,444.0	2,563.7
10	Цахим Өмнөговь	-	-	455.0	144.0	1,650.0	771.2	650.0	438.3	2,755.0	1,353.5
11	Залуус	380.0	341.0	300.0	299.5	1,146.0	967.9	535.0	315.0	2,361.0	1,923.4
12	Говь+Ус	-	-	1,650.0	1,199.8	680.0	146.6	-	-	2,330.0	1,346.4
13	Чадварлаг багш	400.0	364.8	388.0	385.7	711.5	711.4	750.0	305.4	2,249.5	1,767.3
14	Эко жорлон	-	-	150.0	19.8	1,000.0	657.8	40.0	352.5	1,190.0	1,030.1
15	Сүү тараг	200.0	95.0	250.0	239.2	250.0	228.0	250.0	232.3	950.0	794.5
16	Эрүүл шүд	98.9	49.6	156.0	134.3	280.0	244.7	398.0	42.2	932.9	470.8
17	Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая			37.5	25.2	300.0	200.9	450.0	177.7	787.5	403.8
18	Нээлттэй Өмнөговь	-	-	-	-	650.0	568.7	100.0	-	750.0	568.7
19	Эрүүл элэг	67.6	58.0	120.0	-	340.0	61.6	100.0	21.0	627.6	140.6
20	Сурагч солилцоо	50.0	29.6	75.0	49.7	150.0	149.3	350.0	267.3	625.0	495.9
21	Ээлтэй Өмнөговь	70.0	68.5	150.0	146.0	250.0	246.8	150.0	105.3	620.0	566.6

¹ Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл, санхүүгийн эх үүсвэр, хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, хариуцах байгууллагыг тусгана.

22	Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх	-	-	100.0	101.8	100.0	99.8	150.0	128.5	350.0	330.1
23	Эх хүүхдийн эрүүл мэнд	62.5	38.7	57.5	56.3	100.0	76.4	100.0	33.1	320.0	204.5
24	Харшлын эсрэг			50.0	35.6	50.0	46.8	50.0	2.9	150.0	85.3
Жилийн дүн		7,340.0	6,170.5	25,167.6	18,399.6	69,802.0	54,560.3	44,994.8	23,711.4	147,304.4	102,841.8

1.12 Аймгийн төсвийн орлого өсөхийн хэрээр төсөл, хөтөлбөрүүдийн хамрах хүрээ түүнийг дагаад санхүүжилт нэмэгдсэн байна.

БҮЛЭГ 2. ХӨТӨЛБӨРИЙН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТ БУСААР, ЗОРИЛГО, ЗОРИЛТОД НИЙЦЭХГҮЙ, ҮР ДҮНГҮЙ ЗАРЦУУЛСАН НЬ УДИРДАХ БОЛОН ХЯНАЛТ ХИЙХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ХЯНАЛТ СУЛ БАЙГААГ ХАРУУЛЖ БАЙНА.

Б.1. Хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцдоггүй, нэгдсэн судалгаа, мэдээллийн сан байхгүй, өмнөх онуудын баримт материалыг архивын нэгж үүсгээгүй нь хөтөлбөрийн үр дүнг бууруулж байна.

2.1. Төсөл, хөтөлбөрүүдийг дэвшүүлсэн зорилго, зорилт, арга хэмжээний хүрээнд холбогдох хэлтэс хариуцан хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Үүнд:

- Төрийн захиргааны удирдлагын хэлтэс – 1
- Хууль, эрх зүйн хэлтэс – 2
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс – 9
- Нийгмийн бодлогын хэлтэс – 11
- Санхүү, төрийн сангийн хэлтэс - 1

2.2. Аудитаар төсөл хөтөлбөр, зарим арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд илэрсэн зөрчлийг хөтөлбөр тус бүрээр харуулбал:

“ШИНЭ МЯНГАН АЙЛ” ОРОН СУУЦНЫ ХӨТӨЛБӨР

Баригдаж байгаа барилгаас өндөр үнээр байр худалдаж авахаас илүү зорилтот бүлгийн иргэдийг хямд өртөгтэй, чанартай орон сууцаар хангахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байна.

2.1.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 49 дүгээр тогтоолоор иргэдийн орон сууцны нөхцөл сайжруулах, бага дунд орлоготой иргэн, төрийн албан хаагч болон зорилтот бүлгийн иргэдийг хямд өртөгтэй чанартай орон сууцаар хангах орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, түрээсийн орон сууцны санг бүрдүүлэх зорилгоор “Шинэ мянган айл” орон сууцны хөтөлбөрийг баталсан байна.

2.1.2 Уг хөтөлбөр нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоол, АИТХ-ын 2020 оны 2/4 дүгээр тогтоолоор баталсан Өмнөговь аймгийг 2020-2024 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй тус тус уялдсан байна.

2.1.3 “Шинэ мянган айл” орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2021-2024 онуудад 62,357.2 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 44,328.2 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 5. "Шинэ мянган айл" орон сууцны хөтөлбөрийн санхүүжилт

Он	Тогтоолоор баталсан төсөв (сая төгрөг)	Гүйцэтгэл (сая төгрөг)	Зөрүү (сая төгрөг)
2021	3,415.0	3,249.9	165.1
2022	12,056.4	11,311.7	744.7
2023	24,743.0	19,099.4	5,643.6
2024	22,142.8	10,667.2	11,475.6
ДҮН	62,357.2	44,328.2	18,029.0

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс 2024.10 сар

2.1.4 Хөтөлбөрийн хүрээнд иргэдийн орон сууцны нөхцөлийг сайжруулах, хангамжийг нэмэгдүүлэх, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгаж, дахин барилгажуулах, түрээслэх, өмчлөх хэлбэрээр хэрэгжүүлэх Даланзадгад суманд түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, аймаг, сумын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан газарт амины орон сууц хорооллын дэд бүтцийг байгуулах хувийн хэвшлийг бодлогоор дэмжих арга хэмжээний хүрээнд нийт 25,946.99м² талбайтай бүхий 519 байрыг орон нутгийн өмчид шилжүүлж авахаар 59,147.0 сая төгрөгийн гэрээг 30 аж ахуй нэгжтэй байгуулсан байна.

2.1.5 Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд 12,064.14м² талбайтай бүхий 235 байрыг хүлээн авч орон нутгийн өмчид бүртгэсэн бол үлдсэн 13,882.85м² талбайтай 284 байр баригдаж дуусаагүй бөгөөд үүний 4,856.85м² талбайтай 108 байрыг барилгын дахин төлөвлөлтөд орсон, газраа чөлөөлсөн иргэдэд үнэ төлбөргүй шилжүүлэхээр гэрээнд тусгасан байна.

2.1.6 Иргэдийн орон сууцны нөхцөлийг сайжруулах, хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр Ханхонгор, Хүрмэн, Номгон, Булган, Баяндалай, Манлай, Ханбогд, Гурвантэс, Цогтцэций, Цогт-Овоо, Сэврэй, Ноён сумдад ОНТХ-өөр 10 айлын орон сууцны барилгыг барихаар төлөвлөж хэрэгжүүлснээс Ноён, Сэврэй, Ханхонгор, Номгон, Цогтцэций сумдын барилгууд гэрээний хугацаанд баригдаж дуусаагүй байна.

Сумдад баригдаж дуусаагүй барилгууд 2024.10.18-ны өдрийн байдлаар



Номгон сумын 10 айл



Ноён сумын 10 айл



Сэврэй сумын 10 айл



Ханхонгор сумын 10 айл



Цогтцэций сумын 10 айл


2.1.7 Хөтөлбөрийн хүрээнд сумдад хэрэгжүүлсэн "Цогтцэций суманд 10 айлын орон сууц барих" ажлын гүйцэтгэгч Донж Өргөө ХХК-тай холбоотой Дорнод аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 138/ШШ2023/00147 дугаартай захирамжид тусгасны дагуу гэрээний үнийн дүнгийн 20 хувь буюу 142,7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүйд албан шаардлага хүргүүллээ.

2.1.8 Хөтөлбөрийн хүрээнд аймаг, сумын ерөнхий төлөвлөгөөнд тусгасан газар болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилгыг дахин төлөвлөх, барилгажуулах, Даланзадгад суманд түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, хувийн хэвшлийг бодлогоор дэмжих ТАХ-ний хүрээнд 11 хувийн хэвшилтэй ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан байна.

2.1.9 Үүнээс 6 аж ахуй нэгж 2024 онд байгуулсан гэрээний дагуу хугацаандаа ажлаа хэрэгжүүлж байгаа бол "Язгууртны говь" ХХК, "Эрхэст баян говь" ХХК, "Бизнес фокус" ХХК, "Евро ази констракшн" ХХК, "Ивээл хос жаргалууд" ХХК-ууд гэрээний хугацаанд ажлаа хэрэгжүүлж дуусаагүй байна.

2.1.10 Үүнээс "Нанзад хорооллын газрыг дахин төлөвлөж барилгажуулах ажлыг дуусгаж, иргэд хувийн хэвшлийн оролцоотойгоор зарим гэр хорооллыг дахин төлөвлөх" ажлын хүрээнд 2020 онд 72 айлын орон сууцыг эхлүүлэн 2021 оны 10 сарын 01-д дуусгаж хүлээлгэж өгөхөөр "Эрхэст баян говь" ХХК-тай байгуулсан ДТ2020-03 дугаар гэрээний хэрэгжилт одоог хүртэл хангаагдаагүй байна.

Эрхэст баян говь ХХК-ын барилгын ажлын явц 2024.10.18 байдлаар





2.1.11 Гэрээний хэрэгжилт хангаагүй дээрх компанитай төсөл сонгон шалгаруулалтаар 2022 онд 1,799.5 сая, 2023 онд 1,636.2 сая , 2024 онд 998.7 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан бол 2023 онд 1,299.7 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна.

2.1.12 Тус 72 айлын барилгад 2020-2024 онуудад нийтдээ орон нутгийн төсвөөс 6,479.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2.1.13 ХБТХОХ-ийн барилга, нийтийн аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэн нь 2023 оны Түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх багц-4, 2024 оны Түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх багц-6 ажлын даалгаврыг тус тус боловсруулсан байх бөгөөд тэрээр "Эрхэст баян говь" ХХК-ий захиралтай хамаарал бүхий этгээд байна.

2.1.14 "Нанзад хотхон"-ын 72 айлын орон сууцны барилга"-ын барилга угсралтын төсөвт өртгийг 2020 онд 5,448.6 сая төгрөгөөр тогтоож байсан бол 2024 онд магадлалаар оруулан төсөв өртөг 10,609.9 сая төгрөг болгож орон нутгийн өмчид хүлээлгэн өгөх байрын м2-ийг 3.5 сая төгрөгөөр тооцож нийлүүлэх, мөн алдагдлын зөрүүг орон нутгийн төсвөөс шийдүүлэх утга бүхий албан бичгийг аймгийн Засаг даргад удаа дараа хүргүүлсэн байна.

2.1.15 Барилгын ажил эхлэх үеийн ковидын нөхцөл байдалд ижил төстэй үйл ажиллагаа явуулж байсан барилгын компаниуд гэрээний дагуу үүргээ хэрэгжүүлсэн байхад дээрх компани гэрээгээ удаа дараа сунгасан, гэрээний хэрэгжилт хангагдаагүй байхад сонгон шалгаруулалтаар болон шууд гэрээгээр дахин санхүүжилт авсан, орон нутгийн төсвөөс дахин хөрөнгө гаргуулахаар хүсэлт ирүүлсэн нь өөрийн албан тушаалын байдлаа ашиглан мэдээллээр хангасан, аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлсөн байж болзошгүй байна.

2.1.16 Иймд Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3², Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1³-д заасныг зөрчсөн байж болзошгүй гэж үзэж Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1⁴-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторт шилжүүлсэн.

2.1.17 Дээрх компани болон ХБТХОХ-ийн Барилга, нийтийн аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэнтэй хамаарал бүхий "Гал мөнх" ХХК нь Өмнөговь аймаг дахь сум дундын

2 албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах

3 Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

4 Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. Прокурорын байгууллага Ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудиторт хариу мэдэгдэнэ.

иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 143/ШШ2018/00060 дугаартай захирамжийн дагуу 2,574.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төлж барагдуулаагүйд холбогдох арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2.1.18 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй орон сууцны барилга байгууламжид зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхгүй Өмнөговь корпораци ОНӨААТҮГ барилгын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байна.

2.1.19 Дээрх барилгын ажилд Өмнөговь корпораци ОНӨААТҮГ-аас жилд 10-20 удаа захиалагчийн хяналт хийсэн гэх боловч хяналт хийсэн нь баримтаар нотлогдохгүй байна.

"Эрхэст баян говь" ХХК-ын гүйцэтгэж байгаа 72 айлын барилгын ажлын гүйцэтгэл

2021 оны 06 сарын байдлаар



2022 оны 05 сарын байдлаар



2023 оны 07 сарын байдлаар



Эх сурвалж: Санхүүжилт олгосон ажлын баримтаас

2.1.20 Өмнөговь корпораци ОНӨААТҮГ-аас “Гүүд-Айдиз” ХХК-аар Нанзад хотхоны 72 айлын орон сууцны барилгад хяналт шалгалт хийлгэж дүгнэлт гаргуулсан байна.

2.1.21 Уг шалгалтаар зоорины давхрын хучилт хоёр хэсэгт хотойлт өгсөн, гадна зураг төсөлд инженер геологийн дүгнэлт тусгаагүй, зураг төсөлд газар чичирхийллийн зэргийг 9 байхыг 8 гэж буруу бичсэн зөрчлүүд илэрсэн байна.

2.1.22 Өмнөх онуудад байгуулсан гэрээний хэрэгжилт хангаагүй Эрхэст баян говь ХХК-тай 998.7 сая төгрөг, Бизнес Фокус ХХК-тай 1,994.7 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг дахин байгуулж, өмнөх аудитаар өгсөн 332/А1660364 ӨМА-2024/01/НА-СТА-ТЕЗ дугаартай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

2.1.23 Мөн аудитаар гэрээнд заасан хугацаанд ажил гүйцэтгээгүй 9 компанид гэрээний дагуу алданги ногдуулж, хариуцлага тооцоогүй байна.

2.1.24 Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1⁵-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлсэн.

Шинэ мянган айл хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа ажлын гүйцэтгэлд эрх бүхий байгууллагаар хяналт хийлгээгүй, бодит гүйцэтгэлээр санхүүжилт олгодоггүй, гэрээний дагуу алданги ногдуулж, хариуцлага тооцдоггүй, ажил гүйцэтгэх хугацааг удаа дараа сунгаж хөтөлбөрийн үр өгөөжийг бууруулж байна.

2.1.25 Аймгийн Засаг даргын 2020 оны А/1355 дугаар захирамжаар ОНӨГ-т шилжүүлсэн дахин төлөвлөлтийн 2 дугаар байрны В1 давхар, 3 дугаар байрны оффисын өрөөний 626.95м² талбай нь ОНӨГ-ын түрээсийн гэрээнд 625.05м², Болор үнэлгээ ХХК-ын хөрөнгийн үнэлгээний тайланд 618.39м² гэж тус тус зөрүүтэй байгаа нь улсын комисс барилга, байгууламжийг хүлээж авахдаа хэмжилт хийлгэж, баталгаажуулахгүй байгаатай холбоотой байна.

2.1.26 Аймгийн Засаг даргын 2020 оны А/1355 дугаар захирамжаар ОНӨГ-т шилжүүлсэн дахин төлөвлөлтийн 2 дугаар байрны В1 давхрын 408.31м² талбайтай 9 өрөөг - 1 ширхэг 400м², 3 дугаар байрны оффисын 4 өрөө 218.64м² талбайг - 4 ширхэг 525.7 сая төгрөг гэж бөөн дүнгээр бүртгэсэн байна.

2.1.27 Мөн ОНӨГ-т бүртгэлтэй дахин төлөвлөлтийн 3 дугаар байрын оффис, 2 дугаар байрын В1 давхрын өрөөнүүдийг хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй "Болор үнэлгээ" ХХК-аар 2023 оны 11 сард үнэлгээ хийлгэн 307 тоот 62.16м² талбайтай, 149.5 сая төгрөгийн балансын үнэтэй оффисын өрөөг 2024 оны 07 сард дуудлага худалдаагаар 128.0 сая төгрөгөөр худалдан борлуулсан байна.

2.1.28 Орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийг дансны үнээс доогуур өртгөөр худалдан борлуулсан зөрчилд 21.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

2.1.29 Хөтөлбөрийн хүрээнд бий болсон орон нутгийн өмчийн орон сууцыг бүртгэх, түрээслэн, өмчлүүлэх ажлыг “Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпорац” ОНӨААТҮГ хариуцан зохион байгуулж байна.

5 Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

2.1.30 ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 75, ИТХ-ын 2022 оны 7/4 дугаар тогтоолоор баталсан “Орон сууцыг түрээслэн, өмчлүүлэх журам”-д заасны дагуу 2020-2024 онд хөтөлбөрийн зорилтын хүрээнд 322 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулсан байна.

Хүснэгт 6. Хөтөлбөрт хамрагдсан өрх, зорилтот бүлгээр

№	Зорилтот бүлгийн ангилал	Хамрагдсан өрхийн тоо	Хамрагдахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	Шийдвэрлэсэн хувь
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнийг халамжилдаг гэр бүл	28	30	93.3
2	Хувийн байгууллагад ажиллагсад болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид	39	65	60.0
3	Төрийн албан хаагч	116	241	48.1
4	0-18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл	15	45	33.3
5	Өрх толгойлсон эцэг, эх	28	108	25.9
6	Залуу гэр бүл	37	84	44.0
7	Өндөр настан	59	226	26.1
Нийт дүн		322	837	38.5

Эх сурвалж: Өмнөговь Гурван сайхан орон сууцны корпорац ОНӨААТҮГ

2.1.31 Дээрх хугацаанд түрээсийн орон сууцанд хамрагдахаар 837 хүсэлт, материал хүлээж авснаас 38.5 хувийг шийдвэрлэжээ.

2.1.32 Түрээсийн орон сууцанд хамрагдах хүсэлтэй иргэдийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа нь хэрэгцээ шаардлага их байгааг харуулж байна.

2.1.33 Түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх ТАХ-ний хүрээнд худалдан авч байгаа байрны м2-ийн зах зээлийн үнийг мэргэжлийн байгууллагаар бус гүйцэтгэгч талын санал болгосон үнээр орон нутгийн өмчид худалдан авч байна.

2.1.34 Цаашид баригдаж байгаа барилгуудаас өндөр үнээр байр худалдаж авахаас илүү хямд өртөг бүхий зорилтот бүлгүүдэд зориулсан орон сууцыг олноор бий болгоход хөтөлбөрийн зорилтыг чиглүүлэх шаардлагатай байна.

2.1.35 “ӨГОСК” ОНӨААТҮГ 2020-2024 онуудад 31,119.6 сая төгрөгийн өртөгтэй 322 орон сууцны байрыг эрх бүхий байгууллагын шийдвэрээр бүртгэлд тусгасан байна.

2.1.36 Аймгийн ИТХ-ын 2024 оны 17/15 дугаар тогтоолоор “Орон сууцыг түрээслэн өмчлүүлэх гэрээ байгуулах” орон сууцны жагсаалтыг баталж, 2024 оны 19/26 дугаар тогтоолоор “Түрээсийн гэрээнээс өмчлөлийн гэрээнд шилжих иргэдийн нэрсийн жагсаалт”-ыг баталж 36 иргэнтэй өмчлөлийн гэрээ байгуулсан байна.

2.1.37 Аймгийн ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэлтэй байраас холбогдох шийдвэрийн дагуу улс, аймгийн нэрийг дэлхийд гаргасан тамирчид, судлаачдад хүндэтгэл үзүүлэх, хот төлөвлөлтийн дагуу газраа чөлөөлсөн нэр бүхий иргэдийн нөхөн төлбөрт 2-3 өрөө байрыг шилжүүлж данснаас хассан байна.

2.1.38 Мөн одоогийн зах зээлийн ханшнаас хямд өртөгтэй (өмнөх онуудад тухай үеийн зах зээлийн ханшаар бүртгэлд тусгасан) АЗДТГ-т бүртгэлтэй албан тушаалын байрыг эрх бүхий албан хаагчдад түрээслүүлэн өмчлүүлж, бусдад давуу байдал олгосон байна.

2.1.39 Иймд дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

“ЭРҮҮЛ ЭЛЭГ” ХӨТӨЛБӨР

2.2.1 Хүн амын дунд гепатитийн вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэн эмчлэх, улмаар элэгний хатуурал, элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулах зорилгоор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 58 дугаар тогтоолоор “Эрүүл элэг” хөтөлбөрийг баталсан байна.

2.2.2 Тус хөтөлбөрийн хүрээнд 2021-2024 онд 627.6 сая төгрөгийн төсөв баталж гүйцэтгэлээр 140.6 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 7. “Эрүүл элэг” хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан төсөв

Он	Баталсан төсөв /сая төгрөг/	Гүйцэтгэл /сая төгрөг/	Зөрүү /сая төгрөг/	Гүйцэтгэлийн хувь
2021	67.6	58.0	9.60	85.8
2022	120.0	-	120.00	0.0
2023	340.0	61.6	278.44	18.1
2024	100.0	21.0	79.00	21.0
ДҮН	627.6	140.6	487.04	31.2

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

2.2.3 Дээрх төсвийн 41.3 хувийг Даланзадгад сумын өрхийн эмнэлгүүдэд В.С вирусийн урьдчилан сэргийлэх үзлэгт, 32.7 хувийг хүн амын дунд гепатит вирусийн халдварын оношилгоо хийх, хоол боловсруулах замын хавдрыг илрүүлэх үзлэгт аймгийн ЭМГ-т, 11.1 хувийг эрүүл мэндийн байгууллагуудад эм урвалж, 9.2 хувийг 15-17 насны иргэдийг гепатит В вирусийн илрүүлэгт хамруулах, вакцинжуулах, 5.6 хувийг өсвөрийн сургагч багш бэлтгэх, халдвар хяналтын багийг чадавхжуулахад тус тус зарцуулсан байна.

2.2.4 Өмнөговь аймгийн хэмжээнд 2021-2024 онд онд “Эрүүл элэг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж нийт хүн амын 85 хувьд гепатит вирусийн халдварын эрт илрүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Хүснэгт 8. “Эрүүл элэг” хөтөлбөрийн хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан, эмчлүүлсэн иргэдийн статистик

Он	Нийт хүн амын тоо	Урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн тоо	Элэгний А, В, С, Д вирус				
			Шинээр илэрсэн тохиолдлын тоо	Эмчилгээнд хамрагдаж эдгэрсэн хүний тоо	Нас барсан хүний тоо	В, С вирусийн эсрэг вакцинд хамрагдсан иргэдийн тоо	Өвчилсөн бүртгэлтэй иргэний тоо
2021	70455	137145	205	0	19	375 хүн тун	358
2022	72935	76133	533	10	7	2193 хүн тун	979
2023	73842	104032	396	10	12	1321 хүн тун	1692
2024	75458	55802	73	19	24	522 хүн тун	188
Дүн		373112	1207	39	62	4411	3217

Эх сурвалж: Нийгмийн бодлогын хэлтэс

2.2.5 Урьдчилан сэргийлэх үзлэгт давхардсан тоогоор 373,112 иргэнийг хамруулж элэгний В,С вирусийн халдвартай 1207 хүнийг шинээр илрүүлж, эмчилгээнд хамрагдвал зохих иргэдээс 53.3 хувийг хамруулсан байна.

2.2.6 Гепатит В вирусийн эмчилгээнд хамрагдсан өвчтөнүүдээс вирусийн идэвхжил нь дарангуйлагдсан өвчтөний эзлэх хувь 46.9 буюу 180 хүн, С вирусийн эмчилгээний горим бүрэн дуусгасан өвчтөнүүдээс бүрэн эмчлэгдсэн иргэдийн эзлэх хувь 95 байна.

2.2.7 Элэгний В, С вирусийн эсрэг вакцинд 4411 хүн тунг хамруулсан бөгөөд элэгний хавдрын нас баралт 10,000 хүн тутамд 2.9-өөс 3.1 промил болж өссөн бөгөөд өвчтэй иргэдийн тоо 2024 оны хагас жилийн байдлаар 3217-д хүрсэн байна.

2.2.8 Нийгмийн эрүүл мэндийн сургалт нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлэн иргэдийг хамруулсан ч дийлэнх хүн ам амьдралын хэв маяг, зан үйл, эрүүл мэндээ хамгаалах, зөв дадал зуршилд хэвшээгүйгээс өвчлөл буурахгүй, халдварт өртөх эрсдэл өндөр байна.

2.2.9 Иймд Хепатитийн В вирусийн халдварын эсрэг дархлал тогтцын түвшний судалгааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, дархлааны түвшин хангалтгүй бүлгийн хүн амыг нэмэлт дархлаажуулалт хамруулах, мөн сайн дурын дархлаажуулалтад хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.2.10 Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөө болон үр дүнг Эрүүл мэндийн газрын статистик мэдээллийг үндэслэн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тооцож хүрсэн түвшин тооцсон байна.

2.2.11 Хөтөлбөрийн хүрээнд ОНТХ оруулалтаар 2023 онд “Элэгний хатуурал өөхлөлт, хавдар оношлох тоног төхөөрөмж” 349.7 сая, 2024 онд “Элэгний халдварын идэвхжил тоолох лабораторийн тоног төхөөрөмж” 190.0 сая, Говийн Оюу Хөгжлийг дэмжих сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд “Элэгний шалтгаант өвчлөлийн мэс заслын багаж хэрэгсэл” 49.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийгдэж уг хөрөнгийг Өмнөговь аймгийн БОЭТ бүртгэлд тусгасан байна.

2.2.12 Хепатит вирусийн халдвар, элэгний хорт хавдрыг илрүүлэх, онош баталгаажуулахад шаардлагатай лабораторийн орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж, тоног төхөөрөмжөөр хангасан байна.

2.2.13 Үүний үр дүнд орон нутагтаа хавдрын химийн эмчилгээний хэсгийг байгуулан хавдрын хими, хөнгөвчлөх, тусламж үйлчилгээг үзүүлж, В, С вирусийн идэвхжилтийг тодорхойлж Улаанбаатар луу сорьц тээвэрлэх, шинжилгээ өгөх, эмчлүүлэх зэрэг иргэдэд учрах хүндрэл бэрхшээл, санхүүгийн эрсдэлийг бууруулсан байна.

2.2.14 Эрүүл элэг хөтөлбөрийн олон нийтэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээний хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн тоо нэмэгдсэн мөн эрүүл мэндийн салбарын урьдчилан сэргийлэлт, эмчилгээ болон өвчтөний хяналтын системийг сайжруулсан, лаборатори болон тандалтын системийг бэхжүүлсэн, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн зэрэг сайн үр дүнгүүд гарсан байна.

“НУТГИЙН ДЭМ” ХӨТӨЛБӨР

2.3.1 Өмнөговь аймаг нь алслагдсан говийн бүсэд оршдог бөгөөд аймгийн төсвийн байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцаан дахь урамшуулал, идэвхжүүлэлтийг хэрэгжүүлэх замаар тэдгээрийн ажиллах нөхцөл бололцоо, нийгмийн баталгааг хангах зорилгоор ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 89 дугаар тогтоолоор “Нутгийн дэм” хөтөлбөрийг баталсан байна.

2.3.2 Тус хөтөлбөрийн хүрээнд 2021- 2024 онд 57,489.9 сая төгрөгийн төсөв баталж гүйцэтгэлээр 40,433.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 9. "Нутгийн дэм" хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан төсөв

Он	Баталсан төсөв /сая төгрөг/	Гүйцэтгэл /сая төгрөг/	Зөрүү /сая төгрөг/	Гүйцэтгэлийн хувь
2021	1,650.0	1,438.4	211.6	87.2
2022	1,635.0	1,441.8	193.2	88.2

2023	23,554.9	19,603.2	3,951.7	83.2
2024	30,650.0	17,950.2	12,699.8	58.6
ДҮН	57,489.9	40,433.6	17,056.3	70.3

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

2.3.3 Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын батлагдсан орон тооноос ажиллаж байгаа орон тооны гүйцэтгэл, ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажилласан хоногийн гүйцэтгэлээр санхүүжүүлсэн нь төсөвт хэмнэлт гарсан байна.

2.3.4 Тус хөтөлбөрт одоогоор 222 байгууллага хамрагдаж байгаа ба төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах, амьдралын чанарт эерэг нөлөө үзүүлсэн байна.

2.3.5 “Нутгийн дэм” хөтөлбөр анх хэрэгжихдээ улирал тутамд шимтгэлгүй олгодог байсан бол явцын дунд сар бүр нийгмийн даатгалын шимтгэл тооцон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод хамаарах болсон.

2.3.6 Энэ нь Нийгмийн даатгалтын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17, Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дахь заалттай нийцэхгүй тул цаашид хэрэгжүүлэх арга замыг хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

“АГААРЫН БОХИРДОЛГҮЙ ӨМНӨГОВЬ” ХӨТӨЛБӨР

2.4.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 47 дугаар тогтоолоор иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн бохирдлын эх үүсвэрийг багасгаж, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулж эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор “Агаарын бохирдолгүй Өмнөговь” хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан байна.

2.4.2 Тус хөтөлбөрийн хүрээнд 2022- 2024 онд 6,436.2 сая төгрөгийн төсөв баталж гүйцэтгэлээр 3,404.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 10. “Агаарын бохирдолгүй Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан төсөв

Он	Баталсан төсөв /сая төгрөг/	Гүйцэтгэл /сая төгрөг/	Зөрүү /сая төгрөг/	Гүйцэтгэлийн хувь
2022	1,256.2	399.9	856.3	31.8
2023	4,580.0	3,004.8	1,575.2	65.6
2024	600.0	0	600.0	0
ДҮН	6,436.2	3,404.7	3,031.5	52.9

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

2.4.3 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний 76.4 хувийг “Даланзадгад сумын айл өрхийн энгийн галлагаатай зуухыг утаа, агаарын холимгийг дахин шатаах бүтээц бүхий шийдэлтэй утаагүй зуухаар солих” ажилд, 16.3 хувийг “Шинэ технологи, цахилгаан халаагуур, тарифт тоолуур хэрэглээг нэмэгдүүлэх” ажилд, 7.3 хувийг “Цэцэрлэг, сургуулийн дотор агаарын чанарыг сайжруулах” ажилд тус тус зарцуулсан байна.

2.4.4 Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар мэргэжлийн байгууллагуудаас гаргуулан авч үзлээ.

Хүснэгт 11. "Агаарын бохирдолгүй Өмнөговь" хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт		Нэгж	Суурь түвшин /он/	Зорилтот түвшин /он/	2024.09.30 байдлаар
			2020	2024	
Бохирдуулах бодисын бууралт	PM2.5 тоосонцор	мкг/м3	138	100	37
	PM10 тоосонцор	мкг/м4	167	100	54
	Хүхэрлэг хий	мкг/м5	18	15	17
	Азотын давхар исэл	мкг/м6	32	25	25
Шөнийн цахилгаан эрчим хүчний хөнгөлөлтөд хамрагдсан гэр хорооллын хэрэглэгч		тоо	861	5000	6950
2020-380 квт-ын чадалтай цахилгаан халаагуураар халаалтаа шийдвэрлэсэн өрх		тоо	861	5000	1478
Цахилгаан эрчим хүчинд шинээр холбогдсон өрх		тоо	484	1270	6190
Түүхий нүүрсний хэрэглээг халж, сайжруулсан түлш хэрэглэх өрх		тоо	10306	7306	0
Сайжруулсан түлшний үйлдвэр		тоо	0	1	0
Хэрэглэгчийн инженерийн төвлөрсөн хангамжид шилжүүлж, буулгасан халаалтын зуух		тоо	2	25	2
Яндангийн шүүлтүүр суурилуулсан өрх, ААН, байгууллага		тоо	1	20	1
Дэмжлэг авсан зорилтот бүлгийн өрх		тоо	20	300	617
Инженерийн шугам сүлжээнд холбогдох техникийн боломж бүрдүүлэх гэр хорооллын өрх	Цэврийн шугамд	тоо	1622	2430	2476
	Бохирын шугамд	тоо	891	1330	1689
	Дулааны шугамд	тоо	826	1240	2990
Гэр хорооллын айл өрхийн орон сууцны хангамж, орон сууцанд шилжин орсон айл өрх		тоо	279	400	1141
Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдсан төв суурин газрын хүн ам		хувь	12.5	20	9.8
Хийн түлшээр ажиллах авто тээврийн хэрэгсэл		тоо	90	150	144
Евро-5 стандартад нийцсэн шатахууны эзлэх хувь	Авто бензин	хувь	1.8	7.4	1.8
	Дизель түлш	хувь	1.8	7.4	1.8
Хог хаягдлыг боловсруулах үйлдвэр		тоо	0	1	1
Амьсгалын тогтолцооны өвчний бууралт (1000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтээр)		про-милль	25.6	24.0	25.6
Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн бууралт (1000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтээр)		про-милль	23.6	22.8	17.1
Уушгины хатгалгаа (1000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтээр)		про-милль	15.1	14.0	16.9
Гэр хорооллын болон нийтийн эзэмшлийн нэмж зүлэгжүүлсэн талбай		га	9.9	15	14.4
Хот, суурин газрын ногоон байгууламжийн талбай	Сум	га	293	353	510.6

Эх сурвалж: Аудитын судалгаа

2.4.5 Тус хөтөлбөрийн 26 шалгуур үзүүлэлтээс 14 нь хэрэгжсэн, 3 нь дутуу хэрэгжсэн, 9 нь огт хэрэгжээгүй байгаа нь тус хөтөлбөрийн зорилго бүрэн хангагдаагүй, хийсэн арга хэмжээний чиглэл оновчгүй байгааг харуулж байна.

2.4.6 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн зарим ТАХ-ний гүйцэтгэлийг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Даланзадгад сумын айл өрхийн энгийн галлагаатай зуухыг утаагүй зуухаар солих 2,599.9 сая төгрөгийн арга хэмжээ нь аймгийн ИТХ-ын 2021 оны 47 дугаар тогтоолоор баталсан "Агаарын бохирдолгүй Өмнөговь" хөтөлбөрийн Дөрөвт заасан

"Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ"-нд тусгагдаагүй, зорилтуудтай нийцэхгүй,

- Дээрх арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн тооцоо, судалгаагүй боловсруулсан,
- Даланзадгад сумын айл өрхийн энгийн галлагаатай зуухыг утаагүй зуухаар солих 2,599.9 сая төгрөгийн өртөгтэй 2365 ширхэг зуухны 2080 ширхэг зуухыг иргэдэд олгосон баримт, материалыг архивын нэгж үүсгээгүйгээс шалтгаалан 50 ширхэг зуух олгосон иргэдийн мэдээлэл байхгүй,
- Зуух олгосон 2080 иргэнд зуухаа зориулалтын дагуу ашиглаж байгаа болон цаашаа худалдан борлуулсан эсэхэд хяналт хийгээгүй,
- Даланзадгад сумын айл өрхийн энгийн галлагаатай зуухыг утаагүй зуухаар солих ажлын хүрээнд нийлүүлэгдсэн 235 зуухыг одоог хүртэл иргэдэд олгоогүй, айлын хашаанд харуул хамгаалалтгүй байна.



Олгогдоогүй зуух

- "Даланзадгад сумын цэцэрлэг, сургуулийн дотоод агаарын чанарыг сайжруулах" ажлын хүрээнд нийлүүлэгдсэн нэг бүр нь 176,000 төгрөгийн үнэтэй 1420 ширхэг шүүлтүүр нь агаар сэлгэлт хийхэд цонх онгойлгох тоог бууруулаагүй, тус шүүлтүүрийг жилд 2-3 удаа солих шаардлагатай ба нэг удаагийн солих зардал 56,800,000 төгрөг байгаа нь төсвийн байгууллагуудын урсгал зардалд жил бүр ачаалал үүсгэхээр байна.



Суурилуулсан шүүлтүүр

- "Зорилтод бүлгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах Монгол гэрийн дулаалгын багцын ажил"-д 2021-2024 онд нийт 2,437.8 сая төгрөгийн дулаалгын багцыг 1125 өрхөд олгохоор төлөвлөж 534 өрхөд тусгайлсан шалгуур үзүүлэлтгүй олгосон,

- "Зорилтод бүлгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах Монгол гэрийн дулаалгын багцын ажил"-д 2021-2023 онд нийт 1,277.8 сая төгрөгийн дулаалгын багцыг 534 өрхөд олгосон баримт материалыг архивын нэгж үүсгээгүй байна.

2.4.7 Дээрх зөрчлүүдийг арилгах, дахин давтахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

“НЭЭЛТТЭЙ ӨМНӨГОВЬ” ХӨТӨЛБӨР

2.5.1 Аймгийн ИТХ-ын 2023 оны 10/1 дугаар тогтоолоор “Орон нутагт шилжин ирэгсдийн ажиллаж амьдрах орчин, иргэд, ААН, байгууллагыг үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, аймгийн тухай нэгдсэн ойлголт, мэдээллийн сан, нэгдмэл удирдлага, зохицуулалт бүхий төрийн үйлчилгээний цахим систем бий болгох, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор “Нээлттэй Өмнөговь” хөтөлбөрийг баталсан байна.

2.5.2 Тус хөтөлбөрийн хүрээнд 2023- 2024 онд 750.0 сая төгрөгийн төсөв баталж гүйцэтгэлээр 568.7 сая төгрөгийг зарцуулсан

Хүснэгт 12. "Нээлттэй Өмнөговь" хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан төсөв.

Он	Баталсан төсөв /сая төгрөг/	Гүйцэтгэл /сая төгрөг/	Зөрүү /сая төгрөг/	Гүйцэтгэлийн хувь
2023	650.0	568.7	81.3	87.5
2024	100.0	0	100.0	0
ДҮН	750.0	568.7	181.3	75.8

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

2.5.3 Хөтөлбөрөөр “Нээлттэй Өмнөговь сургалт, хэлэлцүүлэг”, “Хариуцлагатай татвар төлөгч арга хэмжээ”, “Эдийн засаг, хөгжлийн бодлого, цаашдын төлөвлөлтийн талаарх мэдээлэл, ярилцлага, сурвалжлаг бүхий 500 сэтгүүл”, “Invest Gobi 2023 хөрөнгө оруулалтын чуулган”, “Өмнөговь аймгийн хөрөнгө оруулалтын чуулган” тус тус зохион байгуулсан байна.

2.5.4 Гэвч “Нээлттэй Өмнөговь” хөтөлбөрийн эхний шатны хүрээнд орон нутгийн төсвөөс 568.7 сая төгрөгийн арга хэмжээ хийсэн боловч хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцох шалгуур үзүүлэлт болох аймагт шилжин ирсэн иргэдийн тоо дөнгөж 3 хувь байна.

2.5.5 Энэ нь аймгийн ИТХ-ын 2023 оны 10/1 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй Өмнөговь" хөтөлбөрийн 9.1.1-д "Аймагт шилжин ирсэн иргэдийн бодит тоон өсөлт 20 хувиас дээш нэмэгдсэн эсэх" гэж заасан шалгуур үзүүлэлтэд хүрээгүй байна.

2.5.6 Иймд хөтөлбөрийн үр дүнг тооцож цаашид хэрэгжүүлэх ажлуудыг оновчтой тодорхойлох шаардлагатай байна.

“ЗАЛУУС” ХӨТӨЛБӨР

2.6.1 Аймгийн ИТХ-ын 2021 оны 63 дугаар тогтоолоор залуучуудад ээлтэй, ажиллаж, амьдрах, авьяас чадвараа нээн хөгжүүлэх орчин нөхцөлийг бий болгож нийгмийн хөгжилд залуусын оролцоог нэмэгдүүлэх замаар залуучуудыг эх оронч үзэлтэй, түүх, өв соёлоороо бахархдаг, гэр бүлийн болон нийгмийн өмнө хариуцлага хүлээх, эрх үүргээ ухамсарладаг эрүүл, хүнлэг иргэн болоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Залуус” хөтөлбөрийг баталсан байна.

2.6.2 Аймгийн хэмжээнд залуучуудад тулгамдсан асуудлыг салбар салбарын төлөөлөл 607 залуучуудаас цахим байдлаар санал авч хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байна.

2.6.3 Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2021-2024 оны 9 сарын байдлаар 2,361.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 1,923.4 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 13. Хөтөлбөрт зарцуулсан төсөв

(сая төгрөг)

№	Хөтөлбөр ийн нэр	2021 он		2022 он		2023 он		2024 оны 9-р сарын байдлаар		Дүн	
		Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
1	Залуус	380.0	341.0	300.0	299.5	1,146.0	967.9	535.0	315.0	2,361.0	1,923.4

2.6.4 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний 17.4 хувийг оюутнуудын дундын оффисын түрээс, тохижилтод, 17.3 хувийг оюутан залуучуудын чуулга уулзалт, өдөрлөгийн арга хэмжээнд, 15.7 хувийг сумдын ЗХТ-ийн ажилтны хөлс, үйл ажиллагаанд, 10.0 хувийг туршлага судлахад, 7.3 хувийг урлаг, спортын их наадамд, 3.0 хувийг ажилтны цалин хөлс, 2.4 хувийг ойн арга хэмжээнд, 2.0 хувийг залуучуудын нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээнд, 1.7 хувийг залуучуудын гарааны бизнесийг дэмжихэд, 1.2 хувийг залуус хөтөлбөрийн сарын аяны арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

2.6.5 "Залуус" хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг 4 зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

- Зорилт 1: Аймгийн 12 суманд шинээр Залуучууд хөгжлийн төвийг байгуулж тус төвөөр нийт 42736 залуучууд үйлчлүүлсэн байгаа нь дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлсэн байна.
- Зорилт 2: Эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд Политехникийн коллеж, ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь салбар сургуулийн оюутнууд болон Улаанбаатар хотод суралцаж буй 1809 оюутан залуучуудыг, 21476 эрэгтэйчүүдийг хамруулан, НҮЭМ-ийн 346 өсвөрийн сургагч багшийг бэлтгэж, өсвөрийн клиникээр 4075 хүүхэд үйлчлүүлсэн байна.
- Зорилт 3: Гарааны бизнесийг 79 залуучууд эрхэлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих модуль сургалтад 2511 залуучууд хамрагдаж, 1093 залуучууд загвар төвөөр үйлчлүүлж ажилд зуучлагдсан байна.
- Зорилт 4: Аймгийн хэмжээнд 48 хосын хурим зохион байгуулж, ХБИ-ийг нийгмийн амьдралд оролцоход дэмжлэг үзүүлэх хувийн туслахаар 70 иргэн ажиллаж, түрээсийн орон сууцад квотоор 108 залуус хамрагдаж, угийн бичиг хөтөлдөг 632 залуу гэр бүл шинээр нэмэгдсэн байна.

2.6.6 Аудитаар анхан шатны баримтын бүрдэлгүй 96.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

2.6.7 Мөн хөтөлбөрийн зардлаас байгууллагын ойн арга хэмжээнд 25.0 сая төгрөг, сумдын залуучууд хөгжлийн төвийн тохижилтод 27.1 сая төгрөг зарцуулсан, шаардлага хангаагүй анхан шатны баримтаар 111.7 сая төгрөг илүү зарцуулсан 23 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

2.6.8 Залуучуудын урлаг, спорт, оюуны их наадмын шагналд олгосон 2.5 сая төгрөгөөс хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй, 200 малчин эмэгтэйчүүдийг зөвлөгөөнд хамруулахаар тооцож санхүүжилт авч гүйцэтгэлээр 150 малчин эмэгтэй хамрагдаж 50 хүнд ногдох 1.2 сая төгрөгийг илүү зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоов.

2.6.9 Тус хөтөлбөрүүдийг хэрэгжих хугацаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн боловч хэрэгжилтийг бодитой үнэлээгүй байна.

2.6.10 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцоогүй, судалгаа, мэдээллийн нэгдсэн сан байхгүй, хэрэгжүүлсэн ажлын баримтыг архивын нэгж үүсгээгүй байна.

2.6.11 Тус хөтөлбөрийн хэрэгжилтээс харахад 12 суманд “Залуучуудын хөгжлийн төв”-ийг шинээр байгуулж, иргэн бүрд хүрч үйлчлэх боломжийг бий болгосон нь онцлог боловч гол үзүүлэлт болох 2 болон 3 дугаар зорилтуудын хэрэгжилт буурсан үзүүлэлттэй байна.

2.6.12 Цаашид хөтөлбөрийн зорилго зорилтыг хэрэгжүүлэхийн тулд төлөвлөсөн арга хэмжээ нь хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгааг харгалзан үзэх шаардлагатай байна.

“ЦЭГЦТЭЙ ГЭР ХОРООЛОЛ” ХӨТӨЛБӨР

2.7.1 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор тус хөтөлбөрийг баталсан байна.

2.7.2 Цэгцтэй гэр хороолол хөтөлбөр болон тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гэр хороололд амьдардаг иргэдийн саналд тулгуурласан гэх боловч нотлох баримт байхгүй байна.

2.7.3 Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2021-2024 оны 9 сарын байдлаар 5,820.9 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 3,449.4 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 14. Хөтөлбөрт зарцуулсан төсөв

/сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	2021 он		2022 он		2023 он		2024 оны 9-р сарын байдлаар		Дүн	
	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
"Цэгцтэй гэр хороолол"	-	-	1,458.0	483.8	3,450.9	2,575.8	912.0	389.8	5,820.9	3,449.4

2.7.4 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний 33.0 хувийг нийтийн орон сууцны гадна засвар, тохижилтод, 21.2 хувийг “Авто машингүй” хүүхдэд ээлтэй нийтийн эзэмшлийн талбай, гудамжийг байгуулахад, 16.6 хувийг “Хашаандаа сайхан амьдаръя” төсөлд, 7.8 хувийг эрчим хүчний жишиг орон сууц, мэдээллийн төв байгуулахад, 6.9 хувийг гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд

холбох дэмжлэгт, 4.8 хувийг “Хашаандаа сайхан амьдаръя экспо” зохион байгуулахад, 4.6 хувийг амины орон сууцны дээвэр дулаалах дэмжлэгт, 2.3 хувийг бусад арга хэмжээнд, 1.5 хувийг ногоон шийдэл, хороолол арга хэмжээнд, 1.2 хувийг Даланзадгад сумын ундны усны худгийн хананы зураг зурах ажилд тус тус зарцуулсан байна.

2.7.5 Хөтөлбөрийн зардлаас 268.6 сая төгрөгөөр “Эрчим хүчний жишиг орон сууц” мэдээллийн төвийг байгуулж тохижуулсан боловч тус төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоон мэдээ, судалгаагүй байгаа нь өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцээгүйг харуулж байна.

2.7.6 “Хашаандаа сайхан амьдаръя” төсөлд 200 өрх, амины орон сууцны дээвэр дулаалах дэмжлэгт 52 өрх, гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбох зардлын дэмжлэгт 442 өрх тус тус хамрагдсан байна.

2.7.7 “Цэгцтэй гэр хороолол” хөтөлбөрийн үр дүнг дараах 4 шалгуур үзүүлэлтийн дагуу тооцсон байна.

- ✓ Шалгуур үзүүлэлт 1: Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд орон нутгийн төсвөөс 3,449.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- ✓ Шалгуур үзүүлэлт 2: Хөтөлбөрийн хүрээнд нийт 300 гаруй өрхөд сургалт мэдээлэл өгч ногоон зээлд, 44 өрхийн дулаан алдагдлыг хэмжиж, 52 өрх амины орон сууцны дээвэр дулаалах дэмжлэгт, 200 өрх “Хашаандаа сайхан амьдаръя” төсөлд, 1089 өрх 70 хувийн хөнгөлөлттэй үнээр олгох зуны хүлэмжийн дэмжлэгт тус тус хамрагдаж, гэр хороололд зөвшөөрөлгүй сунгасан 27 өрхийн хашаа газрын зөрчлийг арилган, 65.8 км цэвэр бохир усны шугам, 14.45 км дулааны шугамыг шинээр байгуулан, 800 м2 талбай бүхий “Автомашингүй” гудамжийг байгуулсан байна.
- ✓ Шалгуур үзүүлэлт 3: Дулаан, төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд 442 өрх холбогдсон байна.
- ✓ Шалгуур үзүүлэлт 4: Хөтөлбөр хэрэгжих хугацаанд судалгааг нэмж баяжуулаагүй, үндэслэх тоон мэдээ байхгүй тул хувийн жинг тодорхойлоогүй байна.

2.7.8 Аудитаар хөтөлбөрийн зардлаас анхан шатны баримтын бүрдэлгүй 138.9 сая төгрөг, төсвийг зориулалт бусаар зарцуулсан 47.5 сая төгрөг, Даланзадгад сумын нийтийн орон сууцны гадна засвар, тохижилтод 1,139.6 сая төгрөг, 5 өрхийг дэмжлэгт давхардуулан 26.9 сая төгрөг олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

2.7.9 Мөн хөтөлбөрийн зардлаас 2022 онд 3.7 сая төгрөг, 2023 онд 3.0 сая төгрөгийн албан томилолтыг эрх бүхий албан хаагчдад олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

2.7.10 Тус хөтөлбөрүүдийг хэрэгжих хугацаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн боловч хэрэгжилтийг бодитой үнэлээгүй зөрчилд давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

2.7.11 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцоогүй, судалгаа, мэдээллийн нэгдсэн сан байхгүй, хэрэгжүүлсэн ажлын баримтыг архивын нэгж үүсгээгүй зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлагыг хүргүүлээ.

2.7.12 Дээрх нөхцөл байдлаас дүн шинжилгээ хийхэд зарцуулсан хөрөнгө, зохион байгуулсан үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үндсэн зорилго болох гэр хороолол руу

чиглэсэн боловч зарим арга хэмжээ нь иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй, хөтөлбөрт хамааралгүй байгаа нь хөтөлбөрийн үр дүнг бууруулж байна.

2.7.13 Цаашид хөтөлбөрийн зорилго зорилтыг хангахын тулд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ нь оновчтой эсэхэд дүн шинжилгээ хийж байх шаардлагатай байна.

“НУТГИЙН ҮЙЛДВЭРЛЭГЧ” ХӨТӨЛБӨР

2.8.1 Аймгийн ИТХ-ын 2021 оны 198 дугаар тогтоолоор үндэсний инновацын тогтолцоонд суурилсан кластер чиг хандлагаар мэдлэгийн болон үйлдвэрлэлийн өртгийн сүлжээг үүсгэн дотоодын болон дэлхийн зах зээлийн эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн өсөлдөх чадвар хөгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх зорилготойгоор 5 зорилтын хүрээнд 3 бүлэг 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

2.8.2 Нутгийн үйлдвэрлэгч” хөтөлбөрт орон нутгийн төсвөөс 2021-2023 онуудад 6,500.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 2,432.3 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 15. Нутгийн үйлдвэрлэгч хөтөлбөрийн баталсан төсөв, гүйцэтгэл.

Хөтөлбөрийн нэр	2022 он		2023 он		Нийт дүн (сая төг)	
	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
Нутгийн үйлдвэрлэгч	3,500.0	305.2	3,000.0	2,127.0	6,500.0	2,432.3

Эх сурвалж: Аудитын судалгаа

2.8.3 Хонь, тэмээний ноосны үйлдвэр барьж ашиглалтад оруулах 6,666.7 сая төгрөгийн өртөгтэй ажлыг 2023 онд төсөл сонгон шалгаруулалтаар “Эрдэнийн гүн говь” ХХК-тай 10 жилийн хугацаатай хүүтэйгээр эхний 3 жил үйлдвэрийн үйл ажиллагаа хэвийн болтол төлөлт хийхгүй нөхцөлтэйгөөр гэрээ байгуулан 1,800.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь нийт хөрөнгө оруулалтын 74 хувийг эзэлж байна.

2.8.4 Хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд үйлдвэрлэлийн өргөтгөсөн худалдаа зохион байгуулах, аж ахуй нэгж, иргэдэд дэмжлэг олгох, гадаад улсад туршлага судлах, уулзалт, сургалт зөвлөгөөн зохион байгуулах, тэмцээн зохион байгуулах, “Өмнөговьд үйлдвэрлэв” борлуулалтын төвийн тохижилт, тоног төхөөрөмж худалдан авахад нийт 581.1 сая төгрөг зарцуулсан байна.

2.8.5 Мөн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнүүд нь үндэсний инновацын тогтолцоонд суурилсан кластерийн чиг хандлагаар мэдлэгийн болон үйлдвэрлэлийн өртгийн сүлжээг үүсгэн дотоодын болон дэлхийн зах зээлийн эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн өсөлдөх чадвар хөгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх гэсэн зорилготой нийцэхгүй байна.

2.8.6 Аудитаар илэрсэн дараах зөрчилд давтан гаргахгүй байх, арилгах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

- Иргэн, аж ахуй нэгжид 93.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон,
- Турк, Тайланд, Вьетнам улсад 67 иргэнийг 115.5 сая төгрөгөөр аялуулсан,
- Ахуйн үйлчилгээний салбар үүссэний 90,91 жилийн ойн арга хэмжээнд 14.0 сая төгрөг,
- "Худалдаа ахуй үйлчилгээ эрхлэгчид 3 үеийн уулзалтын зардалд 10.0 сая төгрөг,
- Афор" ххк-д талбайн түрээсийн зардалд 18.3 сая төгрөг,

- Өмнөговь корпорац ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардалд 61.2 сая төгрөг олгосон.

2.8.7 Хөтөлбөрийн төсвийг зориулалт бусаар, зорилго, зорилтод нийцэхгүй, үр дүнгүй зарцуулсан байгаа нь удирдлага болон хяналт хийх эрх бүхий хэлтэс, албан тушаалтны хяналт сул байгааг харуулж байна.

2.8.8 Аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс нь хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүйд албан шаардлага хүргүүлээ.

2.8.9 Мөн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнг тооцоогүй, 2022, 2023 онд хэрэгжүүлсэн ажлын баримт материалыг архивын нэгж үүсгээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

2.8.10 Цаашид хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээг дэлхийн зах зээлд таниулах, нийлүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

“ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН” ХӨТӨЛБӨР

2.9.1 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2021 оны 32 дугаар тогтоолоор "Монгол улсын үндсэн хууль", "Малын генетик нөөцийн тухай хууль", Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, бусад хууль, "Монгол мал", "Малын эрүүл мэнд", "Монгол малчин хөтөлбөрүүд", "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого", "Эрчимжсэн аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр" зэрэг баримт бичгүүдийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх замаар малчдын орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах, орон нутгийн онцлогт тохируулан мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх замаар хүн амыг аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр тогтмол хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилготойгоор 5 зорилтын хүрээнд 5 бүлэг 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

2.9.2 “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвөөс 4,444.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 2,563.8 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 16. Чинээлэг малчин хөтөлбөрт зарцуулсан гүйцэтгэл.

2021 он		2022 он		2023 он		2024 он		Нийт мөнгөн дүн (сая.төг)	
Төс	гүйц	Төс	гүйц	Төс	гүйц	Төс	гүйц	Төс	гүйц
466.0	333.3	1,000.0	801.2	1,190.0	935.2	1,788.0	494.1	4,444.0	2,563.8

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

2.9.3 Хөтөлбөрийн санхүүжилт жил бүр нэмэгдсэн нь хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний цар хүрээ, хамрагдах хүний тоо нэмэгдсэн, бараа бүтээгдэхүүний ханшийн өсөлтөө шалтгаалсан байна.

2.9.4 Хөтөлбөрийн зардлаас ботгоны урамшуулал олгосон, удам залгасан залуу малчдыг дэмжин гэр олгон, сургалтад хамруулсан байна.

2.9.5 Хөтөлбөрийн хүрээнд малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүнд тэмээний сүүн чихэр, говийн хийцтэй цай, ингэний хоормог зэргийг олон нийтэд таниулан бусад зах зээлд нийлүүлж иргэдийн борлуулалт өссөн эерэг үзүүлэлт гарсан байна.

2.9.6 Аудитаар илэрсэн дараах зөрчилд давтан гаргахгүй байх, арилгах албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

- Хөтөлбөрийн зардлаас Мал эмнэлгийн алба үүссэний 100 жилийн ой, Мал үржлийн алба үүссэний 100 жилийн ойн арга хэмжээнд 139.9 сая төгрөг зарцуулсан,
- Сарлагийн урамшуулалд 4.5 сая төгрөгийг тариф, журамгүй олгосон,
- Төрийн албан хаагчдад 13.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг олгосон,
- Анхан шатны баримтын иж бүрдэлгүй 15.2 сая төгрөг зарцуулсан,
- Малчдад 39.9 сая төгрөгийн бараа тараасан,
- Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд 460 тоо толгой бүхий 132.5 сая төгрөгийн хээлтүүлэгч малыг худалдан авч бүртгэлд тусгаагүй,
- 2023 оны мал болон тэжээвэр амьтдын тооллогод 111.9 сая төгрөг зарцуулсан,
- Аймгийн аварга малчин, тэргүүний тариаланчдыг шагнаж урамшуулахад 62.4 сая төгрөг зарцуулсан,
- Хөрөнгө захиран зарцуулах шийдвэр гаргахдаа тухайн хөтөлбөр, арга хэмжээний холбогдох заалтыг баримталдаггүй,
- Төсвийн хөрөнгөөр хурдан тэмээний уралдаан, тэмээчдийн улсын зөвлөгөөн, Говь фестиваль, аварга малчин, тэргүүний тариаланчийг шагнаж урамшуулахад 46.0 сая төгрөгийн бэлэг, бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан,
- Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжид 19.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн.

2.9.7 Аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс нь хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг арга хэмжээний хүрсэн үр дүн, үр өгөөжийг тооцож, бодитой үнэлээгүй байна.

2.9.8 Мөн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний 2022, 2023 онд хэрэгжүүлсэн ажлын баримт материалыг архивын нэгж үүсгээгүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

2.9.9 Цаашид хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцүүлэн мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, хүн амыг аюулгүй хүнс, чанартай түүхий эдээр тогтмол хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

“ХАРШЛЫН ЭСРЭГ” ХӨТӨЛБӨР

2.10.1 Аймгийн ИТХ-ын 2021 оны 87 дугаар тогтоолоор хүн амыг харшлын өвчлөлөөс анхдагч, хоёрдогчоор урьдчилан сэргийлэх, иргэдийн мэндлэг хандлагыг сайжруулах, харшил, харшилт өвчний оношилгоо, эмчилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар харшлын шалтгаант өвчлөлийг бууруулах зорилгоор 3 бүлгийн хүрээнд 19 арга хэмжээ хэрэгжүүлэхээр “Харшлын эсрэг” хөтөлбөрийг баталсан байна.

2.10.2 Уг хөтөлбөр нь Аймгийн ИТХ-ын 2020 оны 2/4 дүгээр тогтоолоор баталсан Өмнөговь аймгийг 2020-2024 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байна.

2.10.3 “Харшлын эсрэг” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2021-2024 оны 6 сарын байдлаар 155.4 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 107.9 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 17. "Харшлын эсрэг" хөтөлбөрийн санхүүжилт.

(сая төгрөг)

Хөтөлбөрийн нэр	2021 он		2022 он		2023 он		2024 оны 6-р сар		Нийт дүн	
	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
Харшлыг эсрэг	23.0	23.0	35.6	35.6	46.8	46.8	50.0	2.8	155.4	108.2

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

2.10.4 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнд зарцуулсан 108.2 сая төгрөгийн 10.1 сая төгрөгийн албан томилолт, 6.2 сая төгрөгийн хоолны зардал, 2.0 сая төгрөгийн цайны зардал, 5.0 сая төгрөгийн шатахууны зардал, 1.4 сая төгрөгийн боршур, 0.1 сая төгрөгийн усны зардал, 3.6 сая төгрөгийн буудлын зардал, 21.1 сая төгрөгийн сургалтын зардал, 15.4 сая төгрөгийн арьс хатгах, бигнэх сорилын зардал, 0.3 сая төгрөгийн бичиг хэргийн зардал, 19.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 8.5 сая төгрөгийн видео контент, 14.9 сая төгрөгийн бусад зардалд тус тус зарцуулсан байна.

2.10.5 "Харшлын эсрэг" хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг 3 зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

2.10.6 Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд харшил төрүүлэгч бодисын хэмжээ буурсан, гэр хорооллын болон нийтийн эзэмшлийн зүлэгжүүлсэн талбай 3.8 га, хот суурин газрын ногоон байгууламжийн талбай 185.8 га-аар нэмэгдэж, шарилж тайралтыг жилд 3 удаа хийсэн нь дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлсэн байна.

2.10.7 Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд антибиотикийг жороор олгож буй эмийн сан 17 нэмэгдэж, ард иргэдийн дунд харшлын анхдагч, хоёрдогч урьдчилан сэргийлэх үзлэгт 14471 иргэд хамрагдаж, хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн дам тамхидалтад өртөхөөс сэргийлэх, төр, хувийн хэвшлийн бизнес эрхлэгчтэй хамтран иргэдийг эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн, гоо сайхны бүтээгдэхүүнийг зөв зохистой хэрэглэх, иргэдийн антибиотикийн хэрэглээг бууруулах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулсан ч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

2.10.8 Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дэвшүүлсэн гадаад орчны уул уурхайтай холбоотой агаарын бохирдол, тоосжилтоос үүдэлтэй үүсэж байгаа харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх өвчний эрт илрүүлэг, судалгааны ажлыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

2.10.9 Аудитаар илэрсэн дараах зөрчилд давтан гаргахгүй байх, арилгах албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- "Шим билэг" өрхийн эрүүл мэндийн төвд дэмжлэг үзүүлсэн анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, хөтөлбөрийн үр нөлөө, үр дүнг тооцож тайлагнаагүй, хэдэн иргэдэд үзлэг, оношилгоо, эмчилгээ судалгаа хийсэн баримт байхгүй,
- Цогтцэций сумын ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, цэцэрлэгийн хоолонд харшил төрүүлэгчийн агуулагдахууныг тодорхойлох судалгааны ажил зохион байгуулсан баримт байхгүй,
- Хөтөлбөрийн зардлаас 19.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсан,
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн боловч бодитой үнэлээгүй

2.10.10 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцоогүй, судалгаа, мэдээллийн нэгдсэн сан байхгүй, хэрэгжүүлсэн ажлын баримтыг архивын нэгж үүсгээгүй

зөрчилд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлээ.

“ЭРҮҮЛ ШҮД” ХӨТӨЛБӨР

2.11.1 Аймгийн ИТХ-ын 2021 оны 27 дугаар тогтоолоор хүүхдийн шүдний тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангаж, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хүүхдийн шүдний өвчний тархалт, цорлын эрчмийг бууруулах зорилгоор 3 бүлгийн хүрээнд 18 арга хэмжээ хэрэгжүүлэхээр “Эрүүл шүд” хөтөлбөрийг баталсан байна.

2.11.2 Уг хөтөлбөр нь Аймгийн ИТХ-ын 2020 оны 2/4 дүгээр тогтоолоор баталсан Өмнөговь аймгийг 2020-2024 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй тус тус уялдсан байна.

2.11.3 “Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2020-2024 онуудад 895 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 603.3 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 18. “Эрүүл шүд” хөтөлбөрийн санхүүжилт.

(сая төгрөг)

2020 он		2021 он		2022 он		2023 он		2024 оны 6 сар		Дүн	
Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
160.1	110.5	98.9	49.6	156.0	134.3	280.0	266.5	200.0	2.8	895.0	603.3

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

2.11.4 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнд зарцуулсан 603.3 сая төгрөгийн 202.6 сая төгрөгийн цалин хөлс, урамшууллын зардал, 8.1 сая төгрөгийн албан томилолтын зардал, 106.6 сая төгрөгийн эм урвалж, эмнэлгийн хэрэгслийн зардал, 66.2 сая төгрөгийн говь дент шүдний төвд шаардагдах санхүүжилт, 98.6 сая төгрөгийн иргэдийн амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ судалгааны зардал, 51.1 сая төгрөгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтын зардал, 63.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн зардал, 2.0 сая төгрөгийн видео контент, 4.5 сая төгрөгийн бусад зардалд тус тус зарцуулсан байна.

2.11.5 “Эрүүл шүд” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг 3 зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

2.11.6 Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дэвшүүлсэн амны хөндийн шүдний өвчлөлийг бууруулах чиглэлээр “Говь дент” шүдний төвийг 2023 онд үүсгэн байгуулан 150.0 сая төгрөгөөр шаардлагатай багаж тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, засвар тохижилтын ажлыг гүйцэтгэж, 3 эмч, 3 сувилагч, 1 эрүүл ахуйчтай үйл ажиллагааг тогтвортой явуулж байна. Мөн 1 дүгээр сургууль, “Шим билэг” ӨЭМТ-ийн шүдний кабинетын үйл ажиллагааг өргөжүүлж, нүүр ам судлалын чиглэлээр 2 эмч мэргэшүүлж, төр хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй хамтран алслагдсан баг, суманд хүрч ажилласан нь дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлсэн байна.

2.11.7 Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дэвшүүлсэн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын хүүхэд, ард иргэдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зөв хооллолт, эрүүл ахуйн дадал хэвшлийг төлөвшүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран 105263 иргэдэд хүргэж, 37 удаа сургалт сурталчилгаа зохион байгуулсан нь дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлсэн байна.

2.11.8 Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дэвшүүлсэн шүд, амны хөндийн эрүүл мэндийн чиглэлд шинэ технологи нэвтрүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа, шүдний өвчлөлийн бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан, шүдний кабинетын хүчин чадлыг сайжруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

2.11.9 Аудитаар илэрсэн дараах зөрчилд давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- БОЭТ-ийн шүдний кабинетын эмч нарт үр дүнгийн биелэлт тайлагнаж, дүгнүүлээгүй байхад 37.1 сая төгрөгийн урамшуулал олгосон,
- "Шим билэг" Өрхийн эрүүл мэндийн төвийн шүдний кабинетын эмч, 1 дүгээр сургуулийн хүүхдийн шүдний кабинетын эмч нарт үр дүнгийн биелэлт тайлагнаж, дүгнүүлээгүй байхад 59.8 сая төгрөгийн цалин урамшуулал олгосон,
- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцоогүй, судалгаа, мэдээллийн нэгдсэн сан байхгүй, хэрэгжүүлсэн ажлын баримтыг архивын нэгж үүсгээгүй,
- Хөтөлбөрийн зардлаас 63.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсан,
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн боловч бодитой үнэлээгүй.


“ЭКО ЖОРЛОН” ХӨТӨЛБӨР

2.12.1 Өмнөговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 167 дугаар тогтоолоор инженерийн шугамд ойрын хугацаанд холбогдох боломжгүй гэр хорооллын айл өрх, сургуулийн дотуур байр, цэцэрлэг, аялал жуулчлалын бүс, худалдаа үйлчилгээний байгууллагууд эко жорлон /хэрэглэж байгаа хүнийхээ тав тухыг хангасан, агааржуулагчтай, гэрэлтүүлэгтэй, бохирын үнэргүй, нүхэн дэх бохир далдлагдсан, цэвэрлэж арчлах, ариутгахад хялбар, өртөг зардал бага/ арга хэмжээг хэрэгжүүлж, хүрээлэн буй орчин, хөрсний бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тус хөтөлбөрийг баталсан байна.

2.12.2 Хөтөлбөрийн 5.1.1⁶-д заасны дагуу аймгийн Засаг даргын 2021 оны А/1304 дүгээр захирамжаар “Стандартын шаардлага хангасан эко жорлон хийж суурилуулахад тавигдах түр журам”-ыг баталсан байна.

2.12.3 “Эко жорлон” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2022-2024 оны эхний хагас жилийн байдлаар орон нутгийн төсвөөс 1,840.0 сая төгрөгийн төсөв баталж, 983.1 сая төгрөгийн санхүүжилт олгон, 246.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Дүрслэл 1. “Эко жорлон” хөтөлбөрийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гүйцэтгэл. (сая. төгрөг)



Эх сурвалж: Аудитын судалгаа 2024 оны эхний хагас жил

⁶ Эко жорлон хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам батлуулж, мөрдүүлэх

2.12.4 Хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын айл өрхийг эко жорлонтой болгох ажлыг “Жондоо гарден” ХХК -тай 235.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн байна.

2.12.5 Аудитаар хуучин нүхэн жорлонгоо буулгаагүй 7 айл, тусдаа угаадасны нүх байхгүй 4 айл, хашаандаа цэвэр, бохирын шугамд холбогдсон 2 айлын хөтөлбөрт хамруулсан нь журмын шаардлагыг хангахгүй байна.

2.12.6 Аймгийн Засаг даргын 2023 оны А/1314 дугаар захирамжаар эрх шилжүүлэн 14 суманд 660.0 сая төгрөг шилжүүлснээс Баян-Овоо, Мандал-Овоо, Манлай сумд тендер амжилтгүй болсон, Ханхонгор сум цэвэр, бохирын шугам тавигдаж байгаатай холбоотойгоор гүйцэтгэгч компанитай гэрээг сунгасан байна.

2.12.7 Эко жорлон хөтөлбөрийг сумдад хэрэгжүүлэх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын даргын 2023 оны 02/2327 дугаар албан бичгээр иргэнээс төлөх мөнгөн дүнгийн хувийг 25 гэж тусгасан нь аймгийн Засаг даргын 2021 оны А/1304 дүгээр захирамжаар “Стандартын шаардлага хангасан эко жорлон хийж суурилуулахад тавигдах түр журам”-ын 4.1.7⁷-д заасантай нийцэхгүй байна.

2.12.8 Иймд дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2.12.9 Ханхонгор сумын ЗДТГ Эко жорлон суурилуулах ажлыг хэрэгжүүлэхдээ иргэдээс төлөх нийт 18.0 төгрөгийг холбогдох төрийн албан хаагчийн хувийн дансаар дамжуулсан зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

2.12.10 Хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн 1 автомашиныг хөрөнгийн бүртгэлд тусгаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

2.12.11 Тус хөтөлбөрийн хүрээнд 11 сумын 238 өрх буюу 79.3 хувийг эко жорлонтой болгосон байна.

“ХӨГЖЛИЙН ГҮҮР” ХӨТӨЛБӨР

2.13.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 202 дугаар тогтоолоор иргэд, албан хаагчдыг гадаадын улс орнуудад сурах, мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, гадаадын улс орнуудад мэргэжил эзэмшсэн иргэд, албан хаагчдын мэдлэг, боловсролыг нутагшуулах, тэдний оновчтой санал, санаачилгыг дэмжих, соёл, спорт, боловсрол, эрүүл мэнд, үйлдвэрлэл, технологийн харилцах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөтөлбөрт хамрагдсан иргэн, албан хаагчид орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Хөгжлийн гүүр” хөтөлбөрийг баталсан байна.

2.13.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2022-2024 оны эхний 9 сарын байдлаар 5,000.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 4,470.3 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 19. “Хөгжлийн гүүр” хөтөлбөрийн санхүүжилт

Он	Тогтоолоор баталсан төсөв (сая төгрөг)	Гүйцэтгэл (сая төгрөг)	Зөрүү (сая төгрөг)
2022	400.0	371.5	28.5

⁷ Эко жорлон хийж суурилуулах зардлын 30 хувийг аймгийн байгаль хамгаалах сангийн 100110051407 тоот дансанд тушаасан байх. / баримтаар баталгаажуулна/

2023	3,100.0	3,099.8	0.2
2024	1,500.0	999.0	501.0
ДҮН	5,000.0	4,470.3	529.7

Эх сурвалж: Аудитын судалгаа.

2.13.3 Дээрх хүснэгтээс харахад 2023 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөв өмнөх оноос 8 дахин өссөн нь тодотголоор тооцоо судалгаагүйгээр арга хэмжээнд 2,100.0 сая төгрөг нэмж баталсантай холбоотой байна.

2.13.4 Хөтөлбөр хэрэгжүүлсэн хугацаанд давхардсан тоогоор 1912 төрийн албан хаагч, хувийн хэвшлийн ажилчид, малчин, өндөр насны тэтгэвэрт гарсан иргэдийг туршлага судлах богино хугацааны сургалтад хамруулахад 4,470.3 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 20. Хөтөлбөрийн хүрээнд хамрагдсан хүний тоо

№	Улс, хотын нэрс	2022 он	2023 он	2024 он	Хамрагдсан хүний тоо
1	Бүгд найрамдах Солонгос	17	71	40	128
2	Япон	23	13	9	45
3	Австрали	1			1
4	Бүгд найрамдах Польш улс	4			4
5	Люксембург	14			14
6	Бүгд найрамдах Хятад ард улс		1369	302	1671
7	Бүгд найрамдах Энэтхэг		1	2	3
8	Орос		5		5
9	Англи		4		4
10	Тайланд			15	15
11	Америкийн нэгдсэн улс			6	6
12	Канад			1	1
13	Турк			15	15
Нийт хүн		59	1463	390	1912

Эх сурвалж: Аудитын судалгаа

2.13.5 Дээрх судалгаанаас харахад 2023 онд 2,508.2 сая төгрөгөөр 1369, 2024 онд 530.5 сая төгрөгөөр 302 иргэн, төрийн албан хаагч, хувийн хэвшлийн ажилчид, малчин, өндөр насны тэтгэвэрт гарсан иргэдийг зөвхөн БНХАУ-ын Бээжин, Хөх, Санжөү, Шанхай, Ханжоу, Ордос хотуудад явуулсан нь нийт хамрагдсан иргэдийн 87.3 хувийг эзэлж байна.

2.13.6 Тус хөтөлбөрт хамрагдсан иргэнийг хэрхэн сонгон шалгаруулсан, хөтөлбөрийн 5.1-д заасан шаардлагыг хангаж буй талаар ямар нэгэн нотлох баримт байхгүй байгаа нь хөтөлбөрийн ерөнхий шаардлагыг хангаагүйг харуулж байна.

2.13.7 Мөн хөтөлбөрт хамрагдсан иргэнтэй орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах гэрээ байгуулан үүргээ биелүүлээгүй тохиолдолд санхүүгийн дэмжлэгийг тухайн жилдээ багтаан нөхөн төлүүлэхээр заасан энэ заалтыг огт хэрэгжүүлээгүй байна.

2.13.8 Хөтөлбөр хэрэгжих хугацаанд 114 албан хаагч, иргэд, өндөр настанг 2-3 удаа давхардуулан хамруулж 786.4 сая төгрөг зарцуулсан байна.

2.13.9 Аудитаар гүйцэтгэсэн судалгаагаар хөтөлбөрт нийт 1912 хүнийг хамруулснаас 1001 хүн буюу 52.3 хувийг хувийн хэвшил, аж, ахуйн нэгж, 767 хүн буюу 40 хувийг төрийн байгууллагаас, 122 хүн буюу 6.4 хувийг ахмад, өндөр настан, 22 хүн буюу 1.3 хувийг оюутан, сурагчид эзэлж байна.

Хүснэгт 21. Хөтөлбөрийн хүрээнд хамрагдсан хүний тоо.

Он	Төрийн байгууллага	Аж, ахуйн нэгж, хувийн хэвшил	Ахмад настан	Оюутан, сурагч	Нийт хамрагдсан хүний тоо
----	--------------------	-------------------------------	--------------	----------------	---------------------------

2022	58	-	-	1	59
2023	543	833	86	1	1463
2024	166	168	36	20	390
Хамрагдсан хүний тоо	767	1001	122	22	1912

Эх сурвалж: Аудитын судалгаа

2.13.10 Аудитаар аймгийн Засаг даргын 2024 оны А/277 дугаар захирамжаар 2 иргэнд БНХАУ-ын Сычуан мужийн Вибин хотын Шинжлэх ухаан, инженерийн сургуульд суралцахад олгосон 15.0 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

2.13.11 Хөтөлбөрт хамрагдсан иргэдээс 2022 онд Австрали улсын Мельбурн хотод хэлний бэлтгэлд суралцахад 10.0 сая төгрөг, БНПУ-ын Краков хотын ШУТИС-ийн 3 дугаар дамжаанд дэвшин суралцахад 8,0 сая төгрөг, 2023 онд азийн манлайллын солилцооны хөтөлбөр, богино хугацааны сургалтад хамрагдахад 15.6 сая төгрөг, Канад улсын Режайнагийн их сургуульд магистрын сургалтад суралцах зардалд 20.0 сая төгрөгийг 4 иргэнд тус тус олгосон боловч гэрээ хийгээгүй, хөтөлбөрийн зорилго, зорилтдоо хүрсэн талаар үнэлж дүгнээгүй байна.

2.13.12 Мөн "Сурагч солилцоо" хөтөлбөрөөс хэрэгжүүлэх арга хэмжээнд 13.0 сая төгрөг зарцуулсан байна.

2.13.13 Хэрэгжүүлсэн арга хэмжээний 90.6 хувь нь хөтөлбөрийн 3.1.1-д заасан гадаадын их дээд сургууль, олон улсын байгууллага, иргэдтэй хамтран дунд болон богино хугацааны сургалтад хамруулах үйл ажиллагаа эзэлж байна.

2.13.14 Орон нутагт шинэ мэдлэг, технологи, туршлага нэвтэрч, хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр оруулсан талаар баримт материал байхгүй нь хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгүй байгааг харуулж байна.

2.13.15 Батлагдсан журмын дагуу шаардлагад нийцсэн иргэдийг хамруулаагүй, хөтөлбөрийн хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөө, төсвийг 3,382.3 сая төгрөгийг хэтрүүлэн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, үр дүнг шалгуур үзүүлэлтээр тооцдоггүй, хяналт, шинжилгээ, үнэлгээ хэрэгжилтийг бодитой үнэлгээгүй зэрэг нь хөтөлбөрийн үр өгөөжийг бууруулсан байгаад анхаарах ч зорилтод түвшинд хүрэхүйц арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаад албан шаардлага хүргүүллээ.

2.13.16 Цаашид хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа үнэхээр хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тодорхойлж бодитой төлөвлөн хэрэгжилтийн үр дүнг тооцдог байхаар байна.

“ЭЗЭМШСЭН МЭРГЭЖЛЭЭРЭЭ ЭХ НУТАГТАА АЖИЛЛАЯ” ХӨТӨЛБӨР

2.14.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 61 дүгээр тогтоолоор ур чадвар сайтай мэргэжлийн хүнийг орон нутагт урьж ажиллуулан, салбар бүрийг нарийн мэргэжлийн сайн хүний нөөцөөр хангаж, говь нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад чиглэж “Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая” хөтөлбөрийг баталсан байна.

2.14.2 “Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2022-2024 онуудад 787.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 403.8 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 22. "Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая" хөтөлбөрийн санхүүжилт

№	Он	Төлөвлөгөө сая.төг	Гүйцэтгэл сая.төг	Зөрүү сая.төг	Гүйцэтгэлийн хувь
1	2022	37.5	25.2	12.25	67%
2	2023	300.0	200.9	99.09	67%
3	2024	450.0	177.7	272.31	39%
Нийт дүн		787.5	403.8	383.7	51%

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

2.14.3 “Салбар бүрийг ур чадвар сайтай нарийн мэргэжлийн хүний нөөцөөр хангаж, хөгжүүлэх” зорилтын хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд нэг удаагийн шинж чанартай, иргэдэд чиглэсэн байна. Энэ нь хөтөлбөрийн зорилтуудтай нийцэхгүй байна.

2.14.4 Оюутны тэтгэлгийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2022-2024 онуудад 3,250.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 2,653.1 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 23. “Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн санхүүжилт.

№	Он	Төлөвлөгөө сая.төг	Гүйцэтгэл сая.төг	Зөрүү сая.төг	Гүйцэтгэлийн хувь
1	2021	425.0	387.6	37.3	91%
2	2022	625.0	621.5	3.4	99%
3	2023	1,100.0	879.0	220.9	80%
4	2024	1,100.0	764.9	335.0	70%
Нийт дүн		3,250.0	2,653.1	596.8	82%

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

2.14.5 Арга хэмжээний хүрээнд оюутны тэтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ журамд тусгаагүй мэргэжлээр хавтгайруулан олгосон байна.

2.14.6 Мөн гадаадын их дээд сургуульд суралцах оюутанд тавигдах шаардлагыг тодорхой тусгаагүй байна.

2.14.7 Гадаадын их дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудад 133.7 сая төгрөгийн тэтгэлгийг сонгон шалгаруулалтгүй олгосон зөрчилд албан шаардлага, давхардуулан олгосон 16.6 сая төгрөгт төлбөрийн акт тогтоосон.

“ЦАХИМ ӨМНӨГОВЬ” ХӨТӨЛБӨР

2.15.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 70 дугаар тогтоолоор төрийн байгууллагын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, нээлттэй, ил тод байдлыг төлөвшүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны технологид тулгуурласан бизнесийн хөгжлийг дэмжих, бүх салбарын инновацыг тэтгэх, цахим шилжилтийг түргэтгэх зорилгоор “Цахим Өмнөговь” хөтөлбөрийг баталсан байна.

2.15.2 “Цахим Өмнөговь” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2022-2024 онд 2,755.0 төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 1,353.5 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 24. “Цахим Өмнөговь” хөтөлбөрийн санхүүжилт.

/сая төгрөг/

Он	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
2022 он	455.0	144.0	311.0
2023 он	1,650.0	771.2	878.8
2024 оны III	650.0	438.3	211.7
Нийт	2,755.0	1,353.5	1,401.5

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

2.15.3 Хөтөлбөрийн хэрэгжилт үйл ажиллагаанд 2022-2023 онуудад хяналт-шинжилгээ хийсэн хэдий ч хөтөлбөрийн үр дүн, үр нөлөөг нотлох баримтад үндэслэж дүгнээгүй байна.

2.15.4 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн зарим ТАХ-г шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2022 оны А/1660 дугаар захирамжаар 16.6 сая төгрөгийн өртөгтэй "Хөгжимт жүжгийн театр, Байгалийн түүхийн музейн тасалбарыг цахимаар худалдан авах" вэб хийх ажлыг комисс хүлээн авсан тухай акт үйлдсэн боловч ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй,
- Аймгийн Засаг даргын 2022 оны А/1585 дугаар захирамжийн дагуу хийгдсэн "Цахим AR" технологийн тайлбарлагчийг Говийн байгалийн түүхийн музейд хүлээн өгөөгүй, *Цахим AR технологийн тайлбарлагч.*



- Аймгийн Засаг даргын 2022 оны А/1586 захирамжийн дагуу хийгдсэн байгалийн түүхийн музейд "Дижитал музейн аппликейшн" бүтээх ажлыг говийн байгалийн түүхийн музейд мөн хүлээлгэн өгөөгүй, *Дижитал музейн аппликейшний нэвтрэх цонх хэсэг.*



- Хөтөлбөрийн 2022-2024 онд хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцоогүй, судалгаа, мэдээллийн нэгдсэн сан байхгүй, хэрэгжүүлсэн ажлын баримтыг архивын нэгж үүсгээгүй байна.

2.15.5 Дээрх илэрсэн зөрчлүүдэд албан шаардлага, төлбөрийн акт, хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлээ.

“СУРАГЧ СОЛИЛЦОО” ХӨТӨЛБӨР

2.16.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 60 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг богино хугацаанд гадаад, дотоодын сургуулиудад сургалтын хөтөлбөрт хамруулан тэдний бие даан хөгжих, мэдлэг чадвараа дээшлүүлэх, туршлага судлуулах, улс орон, аймаг, бүсийн онцлог, түүх хэл соёл, сургалтын системтэй танилцуулах, гадаадын их дээд сургуульд элсэн суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Сурагч солилцоо” хөтөлбөрийг баталсан байна.

2.16.2 Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр баталсан байна.

- Дотоодын ерөнхий боловсролын болон хувийн өмчийн сургуулиудад сурагч солилцох,
- Өндөр хөгжилтэй гадаадын улс орны сургуулиудад сурагч солилцох,
- Олон улсын болон дотоодын хүүхдийн зуслантай хамтран ажиллаж, хүүхэд залуучуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх.

2.16.3 “Сурагч солилцоо” хөтөлбөрт орон нутгийн төсвөөс 2021-2024 ондуудад 625.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 495.9 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 25. “Сурагч Солилцоо” хөтөлбөрийн санхүүжилт.


Он	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
2021 он	50.0	29.6	20.4
2022 он	75.0	49.7	25.3
2023 он	150.0	149.3	0.7
2024 оны III улирал	350.0	267.3	82.7
Нийт	625.0	495.9	129.1

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс.

2.16.4 Хөтөлбөрийн хүрээнд Бүгд Найрамдах Франц улсын Узас хоттой байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд тус хотын дунд сургуулийн 10 сурагч, 6 багш, эцэг эхийн төлөөлөл 2024 онд ирсэн байна.


2.16.5 БНСУ-ын “Корем тур” байгууллагатай хамран аймгийн сургуулиудын 150 сурагчийг Өвөрхангай Аймгийн Хархорин суманд “Мөрөөдөлдөө хүрэх алхам-2” арга хэмжээнд хамруулсан байна. Үүнээс Даланзадгад хотоос 87 сурагч, сумдаас 63 сурагч хамрагдсан байна.

Дүрслэл 2. “Мөрөөдөлдөө хүрэх алхам-2” арга хэмжээнд хамрагдсан Даланзадгад сумын мэдээлэл.



Эх сурвалж: БНСУ-ын “Корем Тур” байгууллага 2024.8 сар.

Дүрслэл 3. Мөрөөдөлдөө хүрэх алхам-2” арга хэмжээнд хамрагдсан сумдын мэдээлэл.



Эх сурвалж: БНСУ-ын “Корем Тур” байгууллага 2024.8 сар.

2.16.6 Хөтөлбөрийн 3.1-т заасан “Дотоодын ерөнхий боловсролын болон хувийн өмчийн сургуулиудад сурагч солилцох” гэсэн зорилтын хүрээнд 2021-2024 онд ажил зохион байгуулаагүй байна.

2.16.7 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн зарим ТАХ-г шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Бүгд найрамдах Франц улсын Узас хотод 2022 онд Булган сумын 7 сурагч “Сурагч солилцоо” хөтөлбөрт хамрагдаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх албан тушаалтнуудын замын зардлыг Засаг даргын 2022 оны А/481 захирамжаар “Хөгжлийн гүүр” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас зарцуулсан,
- Тус захирамжаар 2 албан тушаалтны замын зардлыг тусгасан ч 3 албан хаагчийн замын зардлыг төлсөн,
- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцоогүй, судалгаа, мэдээллийн нэгдсэн сан байхгүй, хэрэгжүүлсэн ажлын баримтыг архивын нэгж үүсгээгүй байна.

2.16.8 Дээрх илэрсэн зөрчлүүдийг дахин давтаж гаргахгүй байх шаардлагатай байна.

“ЭЭЛТЭЙ ӨМНӨГОВЬ” ХӨТӨЛБӨР


2.17.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 29 дүгээр тогтоолоор “Аймгийн хэмжээнд гарч буй тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол хэргийг бууруулах, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажилд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, иргэд олон нийтийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх замаар иргэдийн амар тайван, амгалан амьдрах орчин нөхцөлийг бүрэлдүүлэх зорилгоор “Ээлтэй Өмнөговь” хөтөлбөрийг баталсан байна.

2.17.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүнг хөтөлбөрийн 6.1-6.3 дахь заалтуудад тодорхойлж үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг боловсруулж, батлуулсан байна.

2.17.3 Гэвч гарах үр дүнд тусгасан “..иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөл сайжирсан байна”, “...урьдчилан сэргийлэх эрх зүйн мэдлэг нэмэгдсэн байна” гэсэн үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь үр дүнгийн өөрчлөлтийг бүрэн тодорхойлж чадахгүй байна. Цаашид хөтөлбөрийн зарим гарах үр дүн, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлж батлуулах шаардлагатай байна.

2.17.4 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2021-2024 онуудад нийт 470.1 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 459.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дүрслэл 4. Ээлтэй Өмнөговь хөтөлбөрийн санхүүжилт.



Эх сурвалж Аудиторын судалгаа (2021-2024 он)

2.17.5 Хөтөлбөрийн зарцуулалтыг арга хэмжээний төрлөөр он тус бүрээр харахад:

- **2021 онд:** Хууль сурталчлах, урьдчилан сэргийлэх нөлөөллийн аян, арга хэмжээнд 45.9 сая төгрөг, хууль зүйн туслалцаа авах өмгөөлөгчтэй хамтран ажиллахад 22.5 сая төгрөг,
- **2022 онд:** Хууль сурталчлах, урьдчилан сэргийлэх нөлөөллийн аян, арга хэмжээнд 47.8 сая төгрөг, хууль зүйн туслалцаа авах өмгөөлөгчтэй хамтран ажиллахад 15.2 сая төгрөг, сургалт зохион байгуулахад 2.7 сая төгрөг, хяналтын камер, хурд сааруулагч, төхөөрөмжийн зардалд 71.2 сая төгрөг,
- **2023 онд:** Хууль сурталчлах, урьдчилан сэргийлэх нөлөөллийн аян, арга хэмжээнд 141.4 сая төгрөг, сургалт зохион байгуулах зардалд 11.7 сая төгрөг, хүүхэд хамгаалал, хохирсон иргэдэд туслалцаа үзүүлэх зардалд 11.1 сая төгрөг, хяналтын камер, өрөөний тохижилтын зардалд 82.5 сая төгрөг,
- **2024 онд:** Хууль сурталчлах, урьдчилан сэргийлэх нөлөөллийн аян, арга хэмжээнд 105.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.17.6 Хөтөлбөрийн зардлаас 2022 онд хөтөлбөрийн зорилт, арга хэмжээнд тусгагдаагүй арга хэмжээ буюу хорих ангиас суллагдсан иргэнд нийгэмшүүлэхэд дэмжлэг үзүүлж 4.9 төгрөг олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

2.17.7 Хөтөлбөр ТАХ-ний зардлаас 2023 онд хөрөнгө оруулалтын шинж чанартай арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчлийг санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлж албан шаардлага хүргүүлсэн байна.

2.17.8 “Ээлтэй Өмнөговь” хөтөлбөрийн 6.1-д “Тодорхой төрлийн гэмт хэрэг (хулгайн гэмт хэрэг, залилах, Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг) буурсан байна” гэсэн үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр 4 төрлийн гэмт хэргийг бууруулах зорилт тавьснаас Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг буурч хүрэх түвшиндээ хүрсэн бол Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хулгайн гэмт хэрэг, залилах гэмт хэрэг өссөн байна.

Хүснэгт 26. Шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Гэмт хэргийн төрөл	2020 он	2022 он		2024	
	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Зорилтот түвшин	09 сарын байдлаар
Хулгайн гэмт хэрэг	108	98	159	88	102
Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	181	171	161	161	157
Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	40	35-37	63	30-35	100
Залилах гэмт хэрэг	26	16	171	6	125

Эх сурвалж: Цагдаагийн газар

2.17.9 Хөтөлбөрийн 6.2-д “Аймгийн төв, гудамж, талбай, сум хоорондын замыг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөл сайжирсан байна” гэсэн үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр хяналтын камерыг нэмэгдүүлж 2024 онд 170-200 болгох зорилт бүрэн хэрэгжиж нийт 228 хяналтын камертай болсон байна. Гэвч иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөл сайжирсан эсэх тодорхойгүй байна.

2.17.10 Хөтөлбөрийн 6.3-д “Иргэдийн гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол аваараас урьдчилан сэргийлэх эрх зүйн мэдлэг нэмэгдсэн байна” гэсэн зорилтын шалгуур үзүүлэлтийн залилах гэмт хэргийн тоо нэмэгдсэн нь хүрэх түвшинд хүрээгүй, зам тээврийн осол аваарын улмаас нас барсан хүний тоо 2020 онтой харьцуулахад 8 хүнээр буурсан хэдий ч хөтөлбөрт батлагдсан хүрэх түвшинд хүрээгүй байна.

2.17.11 Тус хөтөлбөрийн үр дүнгийн нийт 7 шалгуур үзүүлэлтээс хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг бууралт, хяналт камерыг нэмэгдүүлэх гэсэн 2 үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн байна.


“ГОВИЙН ИРЭЭДҮЙ ХҮҮХЭД” ХӨТӨЛБӨР

2.18.1 Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 28 дугаар тогтоолоор Хүүхдийн монгол ёс заншлаа дээдэлсэн, эх оронч, үндэсний бахархлыг уламжлагч, эрх чөлөөт сэтгэлгээтэй, хөдөлмөрч, бүтээлч зөв хандлагыг төлөвшүүлж авьяас чадварыг хөгжүүлэх тогтвортой хөгжлийг хангах зорилгоор баталсан байна.

2.18.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүнг хөтөлбөрийн 6.1-6.4 дэх заалтуудад тодорхойлж үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг боловсруулж, батлуулсан байна.

2.18.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2021-2024 онуудад нийт 4,506.2 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 4,493.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дүрслэл 5. Говийн ирээдүй хүүхэд хөтөлбөрийн санхүүжилт.



Эх сурвалж Аудитын судалгаа (2021-2024 он)

2.18.4 Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээнд тусгагдаагүй 2021 онд Ерөнхий боловсролын сургуулийн 6-р ангийн хүүхдийн үдийн хоолны зардалд 102.4 сая төгрөг, 2023 онд Ерөнхий боловсролын сургуулийн дотоор байрны хүүхдийн хоолны зардалд 595.2 сая төгрөг, Цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэмэгдэл зардалд 1,361.3 сая төгрөг зарцуулсан байна.

2.18.5 Цаашид хөтөлбөрийн зорилт арга хэмжээний хүрээнд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлээ.

2.18.6 Говийн ирээдүй-хүүхэд хөтөлбөрийн хүрээнд 2021-2023 онуудад хийсэн ажлын үр дүнг тооцоогүй, ажлын баримт материалыг архивын нэгж үүсгээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-т.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.2, 35.4 дахь хэсэгтэй нийцэхгүй байна.

2.18.7 Иймд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.


“ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД” ХӨТӨЛБӨР

2.19.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 88 дугаар тогтоолоор “Эх, хүүхэд, охид, эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад нийгэм эдийн засгийн таатай орчин бүрдүүлэн, эцэг эх, иргэд, иргэний нийгмийн оролцоог хангах замаар эрүүл мэндийн хүртээмжтэй, чанартай, ээлтэй тусламж үйлчилгээг тэгш хүргэснээр

сэргийлж болох эрсдэлт хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг тогтвортой бууруулах зорилгоор “Эх хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийг баталсан байна.

2.19.2 Эх хүүхдийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2021-2024 онуудад нийт 320.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 204.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дүрслэл 6. Эх хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөрийн санхүүжилт.



Эх сурвалж АЗДТГ-ын санхүүгийн тайлан (2021-2024 он)

2.19.3 Хөтөлбөрийн зарцуулалтыг арга хэмжээний төрлөөр он тус бүрээр харахад:

- **2021 онд:** Эмчилгээний эм бодист 37.4 сая төгрөг, сургалт, сурталчилгааны арга хэмжээнд 1.2 сая төгрөг,
- **2022 онд:** Сургалт, сурталчилгааны арга хэмжээнд 4.9 сая төгрөг, судалгааны ажилд 1.4 сая төгрөг, тоног, төхөөрөмжийн зардалд 29.9 сая төгрөг,
- **2023 онд:** Эмчилгээний эм бодист 22.8 сая төгрөг, яаралтай тусламжийн үйлчилгээнд 16.7 сая төгрөг, сургалт, сурталчилгааны арга хэмжээнд 7.0 сая төгрөг, тоног, төхөөрөмжийн зардалд 29.8 сая төгрөг,
- **2024 онд:** Эмчилгээний эм бодист 13.5 сая төгрөг, урьдчилан сэргийлэх үзлэг арга хэмжээнд 9.9 сая төгрөг, мэргэжил дээшлүүлэх сургалтад 35.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.19.4 Хөтөлбөр ТАХ-ний зардлаас 2023 онд хөрөнгө оруулалтын шинж чанартай арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчлүүдийг санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлж цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

2.19.5 Эх хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрэх үр дүнгийн 5 шалгуур үзүүлэлтээс жирэмслэлтээр сэргийлэх орчин үеийн арга хэрэглэж байгаа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувь буурсан сөрөг үзүүлэлттэй хүрэх түвшиндээ хүрээгүй байна. Бусад 4 шалгуур үзүүлэлт эерэг буюу зорилтот түвшиндээ хүрсэн байна.

Хүснэгт 27. Шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин (Зорилт 1)

№	Шалгуур үзүүлэлт	2020 он Суурь түвшин	2022 он		2023 он Үзүүлэлт
			Хүрэх түвшин	Үзүүлэлт	
1	Өсвөр насны охидын төрөлтийн эзлэх хувь	6.30%	5.5%	4.90%	4.30%
2	Нөхөн үржихүйн цогц кабинетаар үйлчлүүлсэн эмэгтэйчүүдийн тоо	160	300	-	11897
3	Жирэмслэлтээр сэргийлэх орчин үеийн арга хэрэглэж байгаа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувь	50.7%	55.0%	55.8%	38.0%
4	Өсвөр насны охидын кабинетаар үйлчлүүлсэн хувь	230	400	-	631
5	Үр хөндөлтийн түвшин /1000 амьд төрөлтөд/	431	410	378.9	301.6

Эх сурвалж: Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргадаг “Эрүүл мэндийн статистик мэдээлэл”

2.19.6 Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрэх үр дүнгийн 7 шалгуур үзүүлэлтээс жирэмсний эрт хяналтын хувь буурсан болон перинаталь эндэгдлийн түшин өссөн нь зорилтот

түвшиндээ хүрээгүй байна. Бусад шалгуур үзүүлэлт нь 2022 оны байдлаар сөрөг үзүүлэлттэй байгаа хэдий ч 2023 оны байдлаар эерэг үзүүлэлттэй байгаа нь зорилтот түвшиндээ хүрэх боломжтой байна.

Хүснэгт 28. Шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин (Зорилт 2)

№	Шалгуур үзүүлэлт	2020 он Суурь түвшин	2022 он		2023 он Үзүүлэлт
			Хүрэх түвшин	Үзүүлэлт	
1	Эхийн эндэгдлийн тоо	0	0	0	0
2	Жирэмсний эрт хяналтын хувь	90.2%	90.5%	89.7%	89.7%
3	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш хамрагдсан хяналтын хувь	92.7%	94.5%	93.2%	96.1%
4	Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	11.9	11.2	15.1	10
5	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	14.3	14.0	17.5	10.7
6	Перинаталь эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	11.8	11.1	11.9	11.4
7	Осол гэмтлээс шалтгаалсан, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдол	3	1	2	1

Эх сурвалж: Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргадаг “Эрүүл мэндийн статистик мэдээлэл”

2.19.7 Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрэх үр дүнг Хүүхэд, эх барих эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмчийн хангалт /10000 хүн амд/-ын үзүүлэлтээр авч үзэхэд 2023 онд Хүүхдийн эмч-29 /10000 хүн амд 3.8/, Эх барих эмэгтэйчүүдийн эмч-16 /10000 хүн амд-2.1/ хүрч суурь үзүүлэлтээс буурсан байна.


“ГОВЬ+УС” ХӨТӨЛБӨР

2.20.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 33 дугаар тогтоолоор усны нөөцийн хомсдолоос сэргийлж, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлэн говийн бүс рүү ус дамжуулах хоолой барьж байгуулахыг бодлогоор дэмжиж, хүн ам, бэлчээр, уул уурхайн усан хангамжийг сайжруулах зорилгоор баталсан байна.

2.20.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүнг хөтөлбөрийн 7.1-7.4 дэх заалтуудад тодорхойлсон боловч үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийн суурь түвшин, хүрэх түвшинг хэмжигдэхүйц байхаар боловсруулж, батлаагүй байна.

2.20.3 Говь+Ус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021-2024 онуудад хэрэгжих хөтөлбөр, ТАХ-ний зардлаас нийт 2,370.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 1,386.4 сая төгрөг, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний зардлаас нийт 6,271.7 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 6,271.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дүрслэл 7. Говь+Ус хөтөлбөрийн санхүүжилт




Эх сурвалж Аудитын судалгаа (2021-2024 он)

2.20.4 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021-2024 онуудад хэрэгжих хөтөлбөр, ТАХ-ний санхүүжилтээс 2021 онд Өмнөговь аймгийн хэмжээнд саарал усны ашиглалтын өнөөгийн байдлын судалгааны ажилд 40.0 сая төгрөг, 2022 онд Улааннуур-Даланзадгад-Тавантолгой

чиглэлийн ус дамжуулах байгууламжийн ТЭЗҮ боловсруулах ажилд 1,199.8 сая төгрөг, 2023 онд "Говь+Ус-Говийн бүсийн усан хангамжийн тогтвортой эх үүсвэр усны төслүүдийг хэрэгжүүлэх боломж" сэдэвт эрдэмтэн судлаачдын чуулганд 93.0 сая төгрөг, Бөхийн барилдаан зохион байгуулахад 30.0 сая төгрөг зарцуулсан байна.

Дүрслэл 8. Эрдэмтэн судлаачдын чуулганы зарцуулалт

2.20.5 Хөтөлбөрийн зардлаас "Говь+Ус-Говийн бүсийн усан хангамжийн тогтвортой эх үүсвэр усны төслүүдийг хэрэгжүүлэх боломж" сэдэвт эрдэмтэн судлаачдын чуулганд 93.0 сая төгрөгийг зарцуулалтыг үзвэл нийт төсвийн 51 хувийг хоолны зардалд, 16 хувийг буудлын зардалд, 9 хувийг шатахуун унааны зардалд, 9 хувийг хэвлэл мэдээллийн зардалд, 15 хувийг сургалтын гарын авлага, тараах материалд зарцуулсан байна.



2.20.6 Мөн хөтөлбөрийн зардлаас зорилт, арга хэмжээнд тусгагдаагүй бөхийн барилдаан зохион байгуулсан байна.

2.20.7 Тус алдаа зөрчлүүдийг санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбогдолгүй хандив тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлсэн байна.

2.20.8 Говь+Ус хөтөлбөрийн хүрээнд 2021-2023 онуудад хийсэн ажлын үр дүнг тооцоогүй, ажлын баримт материалыг архивын нэгж үүсгээгүй байна.

2.20.9 Цаашид хөтөлбөрийн үр дүнг тооцож, хийсэн ажлын баримтыг бүрдүүлж Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлээ.

“ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ” ХӨТӨЛБӨР

2.21.1 Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, аймгийн ИТХ-ын 2020 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 04-р сарын 01-ний өдрийн 62 дугаар тогтоолоор тус хөтөлбөрийг баталсан байна.

2.21.2 Хөдөө аж ахуй, уул уурхай, төмөр замын салбаруудыг түшиглэн ажлын байрыг нэмэгдүүлж, жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, хоршоо, нөхөрлөлийг бодлогоор дэмжиж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлын түвшинг бууруулна гэж тодорхойлсон байна.

2.21.3 “Өсөлтийг өрх бүрт” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2021-2024 онуудад 5,600.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 4,196.2 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 29. “Өсөлтийг өрх бүрт” хөтөлбөрийн санхүүжилт.

/сая төгрөг/

Он	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
2021	1,000.0	618.6	381.4
2022	1,000.0	974.6	25.4

2023	1,600.0	1,591.0	9.0
2024	2,000.0	1,012.0	988.0
Нийт дүн	5,600.0	4,196.2	1,403.8

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс.

2.21.4 Хөтөлбөрийн хүрээнд 2021-2023 онуудад хийсэн ажлын үр дүнг тооцоогүй, ажлын баримт материалыг архивын нэгж үүсгээгүй байна.

2.21.5 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн зарим ТАХ-ний гүйцэтгэлтэй танилцахад дараах асуудлууд илэрлээ. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2022 оны А/517 дугаар захирамжаар Политехникийн коллежид төмөр замын мэргэжлийн анги тохижуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн зардалд 20.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн боловч төмөр замын мэргэжлийн зориулалтай анги танхимыг тохижуулаагүй байна. Худалдан авсан бараа материалуудыг зориулалтын дагуу ашиглагдахгүй байна.

Худалдан авсан тоног төхөөрөмж.



- Аймгийн Засаг даргын 2024 оны А/1162 дугаар захирамжаар залуучуудын гарааны бизнесийг дэмжих ажилд шалгарсан төсөл хэрэгжүүлэгчдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулаагүй байхад санхүүжилтийг олгосон байна.
- Аймгийн Засаг даргын 2023 оны А/510 дугаар захирамжаар ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлд хамрагдсан иргэдээс 34 настай 1 иргэнд 1.5 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна.
- 40-өөс дээш насны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлд 2022 онд хамрагдсан иргэдээс 40-өөс доош насны 2 иргэнд тус бүр 5.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна.
- Төмөр замын мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, сургалтын нээлтийн үйл ажиллагааны зардалд Аймгийн Засаг даргын 2022 оны А/161 дугаар захирамжид заасан дүнгээс 1.4 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон байна.

2.21.6 Дээрх илэрсэн зөрчлүүдийг дахин давтаж гаргахгүй байх, үр дүнг тооцож байх шаардлагатай байна.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” ХӨТӨЛБӨР

2.22.1 Гэмт хэргийн хохирогчийн ихэнх хувийг эмэгтэйчүүд, хүүхдүүд байгаа 3 жилийн судалгаанд тулгуурлан аймгийн ИТХ-ын 2021 оны 71 дугаар тогтоолоор “Гэр бүл, хүүхэд,

эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийг 4 бүлгийн хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

2.22.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2021-2024 онуудад 1,390.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 1,386.0 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 30. Хөтөлбөрийн санхүүжилт.

№	Арга хэмжээний нэр	Төсөв (сая төгрөг)	
		Баталсан	Гүйцэтгэл
1	Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв болон гэр бүлийн боловсрол олгох, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг дэмжих, орчин нөхцөлийг сайжруулах	175.0	140.6
2	Архинд донтох эмэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, архинаас татгалзсан иргэдийг ажлын байраар хангах бодлого хэрэгжүүлэх	280.0	340.6
3	Гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг дэмжих	555.0	555.0
4	Гэр бүл хүүхэд эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	350.0	330.0
5	Хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг явуулах	30.0	19.8
Нийт дүн		1,390.0	1,386.0

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс.

2.22.3 Баталсан ТАХ-ний нэр нь аймгийн ИТХ-аар батлуулсан хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээтэй нийцээгүй байна.

2.22.4 Бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор "Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр"-аар хангаж ажилласан нь улсын хэмжээний анхдагч аймаг болсон байна.

2.22.5 Тус үйл ажиллагааг тогтмол явуулснаар 2024 оны 09 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг 28 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.3 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт 31. Түр хамгаалах байрны хөтөлбөр, арга хэмжээ.

/сая төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	2021 он	2022 он	2023 он	2024 он	Нийт
1	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	46.6	47.1	54.7	77.6	226.0
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8.1	10.8	6.5	6.9	32.3
3	Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	5.8	8.2	12.7	8.3	35.0
4	Хангамж, бараа материалын зардал	21.8	14.6	17.7	22.9	77.0
5	Норматив зардал	18.6	21.6	21.6	31.1	92.9
6	Эд хогшил, урсгал засварын зардал	10.9	8.0	6.0	12.8	37.7
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9.8	7.0	5.8	19.1	41.7
8	Бараа үйлчилгээний бусад зардал	1.9	6.5		0.6	9.0
9	Урсгал шилжүүлэг	1.5	1.2		0.7	3.4
Нийт дүн		125.0	125.0	125.0	180.0	555.0

Эх сурвалж: Аудитын судалгаа.

2.22.6 Энэ арга хэмжээнд нийт 555.0 сая төгрөг зарцуулсан нь нийт хөтөлбөрт зарцуулсан зардлын 40 хувийг эзэлж байна.

2.22.7 Уг арга хэмжээнд зарцуулах зардлаас Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар өөрийн үндсэн үйл ажиллагааны шуудан холбооны зардалд 4.1 сая, бичиг хэргийн зардалд 0.6 сая, санхүүгийн программын жилийн төлбөр, ажлын хөлс, аудитын төлбөр, тамганы үнэ

зэрэгт 1.7 сая, дугуй, мотор, машины тосолгооны зардалд 2.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

2.22.8 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн зарим ТАХ-г шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд эрх зүйн туслалцаа үзүүлсэн мэргэжлийн сэтгэл зүйч багш нарт 258.3 сая төгрөгөөр цалинжуулж хөтөлбөрийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан,
- Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сурагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зардлаас 6 сурагчтай гэрээ байгуулж 3.0 сая төгрөгийн урамшуулал олгохдоо хувь хүний орлогын албан татвар суутгаагүй,
- Чадавхжуулах цахим болон танхимын сургалтад 16,4 сая, зөвлөгөөний арга хэмжээнд 11.9 сая, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхтэй сургалтад 18.0 сая, хуулийн эмхэтгэлд 18.9 сая, арга хэмжээ зохион байгуулахад хоолны үнэ 4.5 сая, техник тоног төхөөрөмж 45.0 сая, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахад 4.7 сая төгрөгийг тус тус зарцуулж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан,
- ХЭЗХ-ийн 2 боть, СХДАА-ны 360 ширхэг хуулийн эмхэтгэл, Цагдаагийн газарт 20 ширхэг, ШШГГ-т 20 ширхэг номуудыг бүртгэлд тусгаагүй,
- Эрх зүйн туслалцааны төв байгуулахад 2022 онд 4 суманд өгсөн 20.0 сая төгрөгийн зарцуулалтын тайлан байхгүй, 2023 онд 10 суманд шилжүүлсэн 70.0 сая төгрөгийг ажлын даалгавраас зөрүүтэй тоног төхөөрөмж худалдан авсан,
- Наркалогийн төвийн барилгад 105.0 сая төгрөгийн их засвар хийж байнгын ашиглалтад оруулах улсын комисс хүлээн авсан боловч уг ажлыг капиталжуулж бүртгэлд тусгаагүй байна.

2.22.9 Дээрх илэрсэн зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлээ.

2.22.10 Мөн Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор архи, согтууруулах ундаа, мансууруулах бодисын хамаарал бүхий иргэдэд биеийн болон сэтгэл зүйн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Сэтгэж нийгмийн сэргээн засах "Итгэл дүүрэн амьдрал төв" улсын төсөвт үйлдвэрийн газрыг аймгийн Засаг даргын 2024 оны А/232 дугаар захирамжаар улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулах шийдвэр гаргасан байна.

2.22.11 Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 "Аймгийн Засаг даргын бүрэн эрх" дахь хэсэгтэй нийцээгүй байна.

2.22.12 Иймд дээрх асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх албан шаардлага хүргүүлээ.

“ЧАДВАРЛАГ БАГШ” ХӨТӨЛБӨР

2.23.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 59 дүгээр тогтоолоор мэргэжлийн стандартад суурилсан, уян хатан хэлбэрээр багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжих боломж нөхцөлийг бүрдүүлэн, 21-р зууны боловсролын чиг хандлагад нийцсэн, суралцагчийн хөгжлийн хэрэгцээг хангасан бүтээлч, чадварлаг багшийг бэлтгэх зорилгоор “Чадварлаг багш” хөтөлбөрийг баталсан байна.

2.23.2 “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 2021-2024 оны байдлаар 2,249.5 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 1,767.4 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 32. “Чадварлаг багш” хөтөлбөрийн санхүүжилт.

№	Он	Төлөвлөгөө сая.төг	Гүйцэтгэл сая.төг	Зөрүү сая.төг	Гүйцэтгэлийн хувь
1	2021	400.00	364.81	35.19	91%
2	2022	388.00	385.73	2.27	99%
3	2023	711.50	711.44	0.06	100%
4	2024	750.00	305.38	444.62	41%
Нийт дүн		2,249.5	1,767.4	482.1	79%

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс.

2.23.3 Хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд багшийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулахад чиглэсэн байна.

2.23.4 Тус хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд:

- Өмнөговь аймгийн Боловсрол соёлын газарт 821.2 сая төгрөгийн арга хэмжээ,
- ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь салбарын үйл ажиллагаанд 144.0 сая төгрөгийн санхүүжилт,
- ЭЕШ-т бэлтгэх болон амжилт гаргасан багш сурагчдад 179.5 сая төгрөг,
- Багш нарын чадварыг сайжруулах урт болон богино хугацааны сургалтад 195.0 сая төгрөг тус тус зарцуулжээ.

2.23.5 Хөтөлбөрийн зардлаас 613.4 сая төгрөгөөр тоног төхөөрөмж бэлтгэсэн зөрчилд албан шаардлага хүргүүлжээ.


“СҮҮ ТАРАГ” ХӨТӨЛБӨР

2.24.1 Өмнөговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 86 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд зорилтот бүлгийн бага насны хүүхдийн өсөлт хөгжилт, хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай хүүхдийн хоол тэжээлийг дэмжих чанарлаг, амин дэмээр баялаг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангаж, хүүхдэд ээлтэй хоол тэжээл, сувиллын үйлчилгээг үзүүлснээр бие бялдрын өсөлт, дархлааг дэмжиж хүүхдийн хоцрогдол, өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилгоор “Сүү тараг” хөтөлбөрийг баталсан байна.

2.24.2 “Сүү тараг” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2021-2024 оны эхний хагас жилийн байдлаар орон нутгийн төсвөөс 822.0 сая төгрөгийн төсөв баталж, 771.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Дүрслэл 9. “Сүү тараг” хөтөлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэл.

(сая төгрөг)



2.24.3 Хөтөлбөрийн хүрээнд 2021-2024 онуудад хийсэн ажлын баримт материалыг архивын нэгж үүсгээгүй байна.

2.24.4 Хөтөлбөрийн хүрээнд 2021 онд 2,570 хүүхэд, 2022 онд 8,812 хүүхэд, 2023 онд 7,144 хүүхэд, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 7,766 хүүхэд нийт 26,292 хүүхэд хамрагдаад байна.

Хүснэгт 33. “Сүү тараг” хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо.

№	Хамрагдсан хүүхэд(ангиллаар)	2021 он	2022 он	2023 он	2024 он
1	6-12 сартай хүүхэд	2400	5984	4372	5017
2	2 хүртэлх насны ихэр хүүхэд	15	418	373	218
3	12 хүртэлх насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	60	1194	963	1386
4	Жингийн алдагдалтай, өсөлтийн хоцрогдол	95	1096	1043	816
Дүн		2570	8692	6751	7437
5	Зуны сувилалд хамрагдсан хүүхдийн тоо		120	393	329
Нийт дүн		2570	8812	7144	7766

Эх сурвалж: Аудитын судалгаа.

2.24.5 “Тунамал Сэлэнгэ” ТТБ-тай хамтран “Сүү тараг” хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийлгэсэн байна.

2.24.6 Тус хөндлөнгийн хяналт, үнэлгээгээр хүүхдийн эрүүл мэнд өсөлт хөгжилтөд их ач холбогдолтой, эцэг эхчүүдийн сэтгэл ханамж өндөр байгаа тул хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэх нь зүйтэй гэж дүгнэсэн байна.

ҮНДЭСНИЙ БОЛОН БУСАД ОРОН НУТГИЙН ОНЦЛОГТОЙ СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

2.25.1 Аймгийн ИТХ-ын 2020 оны 2/4 дүгээр тогтоолоор баталсан Өмнөговь аймгийг 2020-2024 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд тусгасан дагуу арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

2.25.2 Үндэсний болон орон нутгийн онцлогтой спортыг хөгжүүлэх ТАХ-нд 2021-2024 онд 4,490.0 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 3,769.4 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 34. ТАХ-ний төсвийн гүйцэтгэл.

Он	Батлагдсан төсөв сая төгрөг	Гүйцэтгэл сая төгрөг	Зөрүү сая төгрөг	Гүйцэтгэлийн хувь
2021	300.0	284.6	15.40	94.9
2022	520.0	457.6	62.40	88.0
2023	1,500.0	1,412.1	87.90	94.1
2024	2,170.0	1,615.1	554.90	74.4
ДҮН	4,490.0	3,769.4	720.60	87.9

Эх сурвалж: Нийгмийн бодлогын хэлтэс.

2.25.3 Тус арга хэмжээний зардлаас 28.4 хувь буюу 1,071.1 сая төгрөгийг аймгийн баяр наадмын үйл ажиллагаанд зарцуулжээ.

2.25.4 Орон нутгийн төсвийн орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор ТАХ-ний төсвийг жил бүр нэмэгдүүлэн баталсан боловч төсөл арга хэмжээний хүрэх үр дүнг тодорхойлдоггүй байна.

2.25.5 Үндэсний болон орон нутгийн онцлогтой спортыг хөгжүүлэх ТАХ-ний хүрээнд спортын холбоо, төрийн бус байгууллагууд, мэргэжлийн клубүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Хүснэгт 35. Дэмжлэг үзүүлсэн спортын холбоо, клубүүд

/сая төгрөг/

№	Спортын холбоодын нэр	Арга хэмжээний тоо	Зарцуулсан мөнгөн дүн	№	Спортын холбоодын нэр	Арга хэмжээний тоо	Зарцуулсан мөнгөн дүн
1	Говийн хүчтэн дэвжээ	11	147.5	18	Өмнөговь аймгийн Хөл бөмбөгийн холбоо	3	14.7
2	Монголын үндэсний бөхийн холбоо	46	124.5	19	Хулан софт волейболын холбоо	4	33.0
3	Өмнөговь аймгийн ахмад харваачдын шагайн холбоо	1	9.0	20	Өмнөговь цэц шатрын холбоо	8	74.5
4	Говь гурван сайхан мэргэчүүд	8	271.6	21	Даян хаан билигт шатрын клуб	1	3.0
5	Өмнөговь үндэсний сурын холбоо	12	138.0	22	Өмнөговь аймгийн жудо бөхийн холбоо	4	37.3
6	Үндэсний Сурын холбоо	1	10.0	23	Монголын жудо бөхийн холбоо	1	6.0
7	Өмнөговь аймгийн морин спорт уяачдын өмнийн говийн хүлэг	9	175.8	24	Сагсан бөмбөг тэмүүлэл	2	30.0
8	Өмнөговь аймгийн бөхийн холбоо	6	70.7	25	Ёлууд сагсан бөмбөгийн клуб	3	41.2
9	Өмнөговь аймгийн ширээний теннисний холбоо	4	19.5	26	Алтан бөмбөгийн ёлууд сагсан бөмбөгийн холбоо	1	8.9
10	Өмнөговь аймгийн чөлөөт бөхийн хан дэвжээ	4	60.0	27	Шовх шонхор клуб ТББ	2	13.0
11	Өмнөговь хур волейболын холбоо НҮТББ	8	176.2	28	Өмнөговь аймгийн Боксын холбоо	7	84.6
12	Өмнөговь аймгийн хөнгөн атлетикийн ахмад тамирчдын холбоо	4	32.0	29	Гайхамшигт говь аялал жуулчлалын холбоо	2	86.2
13	Өмнөговь аймгийн даян хааны хүчтэн пауэрлифтинг бодибилдинг	1	3.0	30	Даян хааны отог	1	10.0
14	Өмнөговь аймгийн дайчин таеквондогийн холбоо	3	31.5	31	Говь унадаг дугуйн холбоо	2	8.1
15	Монголын Таеквондогийн холбоо	1	40.0	32	Өмнөговь аймгийн Говийн хулан адуучдын холбоо	1	8.0
16	Говь пантера жюү жицүгийн холбоо	3	14.0	33	Өмнөговь аймгийн говийн загас усан спортын холбоо НҮТББ	1	2.5
17	Юлтимакс холимог тулааны холбоо	2	10.5	34	Өмнөговь аймгийн бадминтоны холбоо НҮТББ	1	8.0

НИЙТ ДҮН

1,802.5

Эх сурвалж: Нийгмийн бодлогын хэлтэс

2.25.6 Олон улс, хот болон улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох болон үндэсний онцлогтой спортыг хөгжүүлэх 34 спортын холбоо, төрийн бус байгууллага, клубүүдэд 1,802.5 сая төгрөг, 51 баг тамирчдад 211.1 сая төгрөгийг тус тус бэлтгэл сургуулилт хийх, уралдаан тэмцээнд оролцоход болон баяр наадам зохион байгуулахад зориулж олгосон байна.

2.25.7 Аймгийн ИТХ-ын 2023 оны 14/11 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу Өмнөговь аймгийн соёл, урлаг, спортын чиглэлээр улс, тив дэлхийн чанартай тэмцээн уралдаанд амжилт гаргасан уран бүтээлч, тамирчинд 2023 онд 51.6 сая төгрөгийн шагнал урамшуулал олгосон байна.

2.25.8 ТАХ-ний хүрээнд аймгийг төлөөлж оролцсон баг тамирчид нутгийн төдийгүй Монгол Улсын нэрийг дэлхийд гаргасан томоохон амжилтууд гаргасан үр дүнг үзүүлсэн байна.

2.25.9 Мөн Өмнөговь аймагт шатрын спортоор тогтмол хичээллэж буй хүүхдүүдийн тоо 200, шатар тоглож сурсан хүүхдүүдийн тоо 4000 давсан бөгөөд шатрын спортын дэд мастер цолтон 10, спортын мастер 1, улсын шүүгч 3, олон улсын дасгалжуулагч цолтон 1 төрөн гарсан байна.

2.25.10 Дэмжлэг үзүүлэх шалгуур үзүүлэлт, тоо хэмжээ, давтамжийг журмаар зохицуулаагүйгээс санхүүгийн дэмжлэгийг харилцан адилгүй, ялгавартай олгосон байна.

2.25.11 Иймд орон нутгийн эрх хэмжээний хүрээнд уг асуудлыг журмаар зохицуулж төсвийг хэмнэлттэй үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах, үр өгөөжгүй арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2.25.12 Арга хэмжээний хүрээнд баяр наадам зохион байгуулах, үндэсний онцлогтой спортыг хөгжүүлж, сурталчлахад зориулж бөхийн холбоонд 342.7 сая, сурын холбоонд 147.9 сая, шагайн холбоонд 280.6 сая, морин спорт уяачдын холбоонд 175.8 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

2.25.13 Өмнөговь аймгийн Засаг даргын 2021, 2022, 2023 оны захирамжаар Өмнөговь аймгийн үндэсний бөхийн дасгалжуулагчаар нэр бүхий хүмүүстэй гэрээ байгуулан 57.6 сая төгрөгийн цалин олгосон байна.

2.25.14 Дээрх дасгалжуулагчдын хийсэн ажил тодорхойгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчилд 2023 оны ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлсэн.

2.25.15 Мөн бөхийн барилдаан зохион байгуулахтай холбоотой зарцуулах 50.1 сая төгрөгийг Өмнөговь аймгийн Бөхийн холбооны нарийн бичгийн даргын хувийн дансанд шилжүүлсэн, аймгийн Засаг даргын 2024 оны А/349 дугаар захирамжаар Өмнөговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын говийн бүсийн тэмцээний зардалд 18.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

2.25.16 Уг хөтөлбөрөөс 2024 онд төсвийн тооцоолол, ажлын удирдамж, гэрээ хэлцэл, хүсэлт, гүйцэтгэсэн ажлын болон зарцуулалтын тайлангүй, анхан шатны баримтын иж бүрдэлгүй хангаагүй 452.8 сая төгрөг зарцуулсан байна.

2.25.17 Иймд Төсвийн тухай хуулийн 16 дугаар 16.5.2⁸-д заасныг хэрэгжүүлээгүй, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

2.25.18 Соёл, спортын бодлого хариуцсан мэргэжилтэн албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлэн, хариуцсан ажлаа өөрөө тайлагнаж, үр дүнг тооцоогүй, судалгаа, мэдээллийн нэгдсэн сан байхгүй, хэрэгжүүлсэн ажлын баримтыг архивын нэгж үүсгээгүйд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

2.25.19 Цаашид санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэхээс илүүтэй материаллаг баазыг хөгжүүлэх, ирээдүйд үр өгөөжөө өгөх бодитой арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Б.2 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнд тавих хяналт хангалтгүй байна.

2.26.1 Хөтөлбөрөөс гадна хэрэгжүүлсэн зарим арга хэмжээг шалгахад илэрсэн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

- Аймгийн Засаг даргын захирамжаар орон сууцны нөхцөлөө сайжруулах дэмжлэгийг 2021-2024 онд 833 төрийн албан хаагчдад нийт 4,962.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн боловч дэмжлэгт хамрагдсан төрийн албан хаагчдын нэгдсэн мэдээллийн сан үүсгээгүйгээс шалтгаалан өмнө нь энэ төрлийн тусламж, дэмжлэг авсан, гэр бүлийн гишүүн давхардаж байгаа эсэхэд хяналт хийгдээгүй олгосон,
- Орон сууцны нөхцөлөө сайжруулах дэмжлэгт хамрагдсан 833 төрийн албан хаагчдын төрийн албан хаасан хугацаа, орон сууц худалдан авах, шинээр бариулах, хашаандаа байшин барих зориулалтаар авсан эсэх нь нотлогдохгүй,
- Орон сууцны нөхцөлөө сайжруулах дэмжлэгийг 2 төрийн албан хаагчдад тус бүр 5.0 сая төгрөгөөр илүү тооцож олгосон,
- Аймгийн Засаг даргын захирамжаар эмчилгээний тусламжийг 2021-2024 онд нийт 146.0 сая төгрөгийг 28 төрийн албан хаагчдад үзүүлсэн боловч өвчний онош, эмчлүүлэх хугацаа зэрэг нь баримтаар нотлогдохгүй,
- Аймгийн Засаг даргын захирамжаар мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд нь сургалтын төлбөрийн дэмжлэгийг 2021-2024 онд 44 төрийн албан хаагчдад нийт 185.9 төгрөг олгосон ба дэмжлэгийг орон нутагт хэрэгцээтэй мэргэжил мөн эсэхийг харгалзаж үзээгүй,
- Мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд нь сургалтын төлбөрийн дэмжлэг авсан 44 төрийн албан хаагчийг төрийн албанд ажиллаж байгаа, сурч байгаа эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй, үр дүнг тооцоогүй,
- Баяр наадмын арга хэмжээнд зарцуулахаар төсөв батлагдсан ч дахин арга хэмжээний зардлаас 140.0 сая төгрөгийг "Баяр наадам"-ын үйл ажиллагаанд зарцуулсан,
- Уран бүтээлчдэд тайлан тоглолт, бүтээл туурвих дэмжлэгийг гэрээгүй, хийсэн ажлын тайлан, нотлох баримтгүй 107.1 сая төгрөг зарцуулсан,
- Сангийн далай хийдийн харуул, хамгаалалтын ажилтны цалингийн зардалд 22.1 сая төгрөг зарцуулсан,
- Арга хэмжээний зардлаас 500.0 сая төгрөгийг тендер шалгаруулалт зохион байгуулаагүй байхад барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн,

⁸ "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих

- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд олон нийт, хувийн хэвшлийн сургалт, хичээлээс гадуур хөтөлбөрийн сургалтын байгууллагыг бодлогоор дэмжих ажлын хүрээнд нэг удаагийн буцалтгүй дэмжлэг олгох арга хэмжээг тооцоо судалгаагүй 1,500.0 сая төгрөг баталсан,
- Биеийн тамир спортын газрын усан бассейны автомат цаг худалдан авахад 184.2 сая төгрөг зарцуулсан,
- Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот бүлгийн иргэдийн хөгжил хамгааллыг сайжруулах арга хэмжээний зардлаас 24.1 сая төгрөг,
- 40-өөс дээш настай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжил хамгааллыг сайжруулах арга хэмжээний зардлаас 31.7 сая төгрөгийг анхан шатны баримтын иж бүрдэлгүйгээр зарцуулсан,
- Олон улсын болон дотоодын үзэсгэлэн, уулзалт, зөвлөгөөн, сургалтад оролцох арга хэмжээний зардлаас Баяндалай, Булган сумын баяр наадмын зардалд 19.9 сая төгрөгийг олгосон,
- Зорилтот бүлгийн иргэдийн амьдрах орчин, амьдралын чанарыг сайжруулах арга хэмжээний зардлаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч хөдөлмөр эрхлэх боломжгүй эцэг, эхийн НДШ болон ЭМД-д 28.1 сая төгрөг төлсөн,
- Орон нутгийн бичил болон жижиг, дунд үйлдвэрлэлийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжин өргөжүүлэн хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, төслийн хэрэгжилт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй,
- Арга хэмжээний зардлаас 19.9 сая төгрөгийн ХХААГ-ын "Стратеги төлөвлөгөө"-г боловсруулах ажлын гэрээний хэрэгжилт хангуулаагүй,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон аймгийн төсвийн байгууллагуудад мөрдөгдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг" боловсруулах ажлыг Актив аудит ХХК, Адвэнсэд адвайсори ХХК-тай 2023 оны 12 дугаар сарын 14 өдөр нийт 38.9 сая төгрөгийн гэрээ байгуулж гэрээний төлбөрийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон аймгийн төсвийн байгууллагуудад мөрдөгдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг" боловсруулах ажлыг Актив аудит ХХК, Адвэнсэд адвайсори ХХК-тай нийт 38.9 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлж 2024 оны 07 дугаар сард хүлээн авсан боловч одоог хүртэл хөрөнгөд бүртгээгүй,
- "Мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний чанар хүртээмж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх" арга хэмжээний зардлаас 113.9 сая төгрөгийн хөрөнгө /34 ширхэг мотоцикл/ худалдан авсан,
- "Нийтийн биеийн тамирыг дэмжин хөгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний хүрээнд 2023 онд хийсэн ажлын баримт материалыг архивын нэгж үүсгээгүй байна.

2.26.2 Аймгийн Засаг даргын 2024 оны А/1200 дугаар захирамжид хөрөнгийн бүртгэлд тусгахаар захирамжилсан заалт нь хөрөнгө оруулалтыг хуваарийн дагуу буцаан төлөхөөр тусгасан гэрээний заалттай зөрчилдөж байгаа тул алдаатай албан бичиг төлөвлөсөн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүллээ.

2.26.3 Аймгийн Засаг даргын Тамгын газрын болон Биеийн тамир спортын газрын мэргэжилтэнг нийтийн биеийн тамирын чиглэлээр БНСУ-д туршлага судлахад Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 12-ны А/2335 дугаар захирамжаар тус бүрд 5.0 сая

төгрөгийн дэмжлэг олгосон боловч явсан эсэх нь нотлогдоогүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.

2.26.4 Хэрэгжүүлсэн арга хэмжээнийн үр дүнг тооцдоггүй, судалгаа, мэдээллийн сан байхгүй, хэрэгжүүлсэн ажлын баримтыг архивын нэгж үүсгээгүй зөрчил түгээмэл илэрсэн нь хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

2.26.5 Цаашид санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэн иж бүрэн, үнэн зөв байдлыг ханган хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төсөв боловсруулахдаа хуулийн дагуу төлөвлөдөггүй, түүнд тавих дотоод хяналт сул байгаагаас төлөвлөлтийн шаардлага хангагдахгүй батлагдаж байна.
- Хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлт оновчгүй, хүрэх үр дүнг хэт ерөнхий төлөвлөж байна.
- Шинэ мянган айл хөтөлбөрийн хүрээнд ажил гүйцэтгэж буй аж ахуй нэгж байгууллагын гэрээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг үнэн бодитой хэрэгжүүлээгүй, гүйцэтгэлээр санхүүжилт олгоогүй, гэрээний дагуу алданги ногдуулж, хариуцлага тооцоогүй, ажил гүйцэтгэх хугацааг сунгасан байна.
- Өмнөх онуудад байгуулсан гэрээний хэрэгжилт хангаагүй аж ахуй нэгжтэй дахин гэрээ байгуулж, аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.
- Гэрээнд заасан хугацаанд ажил гүйцэтгээгүй 9 компанид гэрээний дагуу алданги ногдуулж, хариуцлага тооцоогүй байна.
- Орон нутгийн өмчид хүлээн авах орон сууцыг улсын комиссын актаар хүлээж авахдаа хэмжилт хийлгэж баталгаажуулдаггүй байна.
- Түрээсийн орон сууцад хамрагдахаар 837 хүсэлт, материал хүлээж авснаас 38.5 хувийг шийдвэрлэсэн байна.
- Аймгийн ЗДТГ-т бүртгэлтэй зах зээлийн үнээс хямд өртөгтэй албан тушаалын байрыг ӨГОСК ОНӨААТҮГ-т шилжүүлэн албан тушаалтанд түрээслүүлэн, өмчлүүлж бусдад давуу байдал олгосон байна.
- Баригдаж байгаа барилгуудаас өндөр үнээр байр худалдаж авахаас илүү хямд өртөг бүхий зорилтот бүлгүүдэд зориулсан орон сууцыг олноор бий болгоход хөтөлбөрийн зорилтыг чиглүүлэх шаардлагатай байна.
- Төсөл арга хэмжээнээс санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлэхээс илүү материаллаг баазыг хөгжүүлж, хөрөнгө оруулалт хийх нь урт хугацаанд үр өгөөжөө өгөхөөр байна.
- Дэмжлэг үзүүлэх шалгуур үзүүлэлт, тоо хэмжээ, давтамжийг журмаар зохицуулаагүйгээс үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийг харилцан адилгүй, ялгавартай олгосон байна.
- Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 14/11 дугаар тогтоолоор амжилт гаргасан уран бүтээлчид, тамирчдын хөдөлмөр, ур чадварыг үнэлж урамшуулсан нь цаашид амжилт гаргахад томоохон хөшүүрэг болох сайн талтай байна.
- Далд хэлбэрээр үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой илрүүлэлтийг нэмэгдүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан боловч зөрчил буураагүй байна.
- Хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах "Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр"-ыг тохижуулан үйл ажиллагааг тогтмолжуулснаар гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг 28 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.3 хувиар буурсан байна.
- Гепатит В вирусийн эмчилгээнд хамрагдсан өвчтөнүүдээс вирусийн идэвхжил нь дарангуйлагдсан өвчтөний эзлэх хувь 46.9 буюу 180 хүн, С вирусийн эмчилгээний горим бүрэн дуусгасан өвчтөнүүдээс бүрэн эмчлэгдсэн иргэдийн эзлэх хувь 95 байна.
- Техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг зөвхөн бодлого хариуцсан мэргэжилтэн боловсруулж байгаа нь оновчгүй байна.
- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй орон сууцны барилга байгууламжид зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхгүй Өмнөговь корпораци ОНӨААТҮГ барилгын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байна.

- Хөтөлбөрийн төсвийг зориулалт бусаар, зорилго, зорилтод нийцэхгүй, үр дүнгүй зарцуулсан нь удирдах болон хяналт хийх эрх бүхий албан тушаалтны хяналт сул байгааг харуулж байна.
- Зарим төсөл арга хэмжээний хүрэх үр дүнг тодорхойлоогүй төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.
- Хөтөлбөрүүдийг хэрэгжих хугацаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн боловч хэрэгжилтийг бодитой үнэлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга О.Эрдэнэ-өрнөх танаа:

- Төсөл, хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтийг оновчтой, хүрэх үр дүнг тодорхой байхаар батлах,
- АЗДТГ-т бүртгэлтэй зах зээлийн үнээс хямд өртөгтэй албан тушаалын байрыг Гурван сайхан орон сууцны корпорац ОНӨААТҮГ-т шилжүүлж эрх бүхий албан тушаалтанд түрээслүүлж, өмчлүүлж бусдад давуу эрх олгохгүй байх

Аймгийн Засаг дарга Н.Энхбат танаа:

- Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг оновчтой, үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаатай байхаар төлөвлөх
- Хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах арга хэмжээний тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлж төлөвлөх,
- Хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг тооцож гүйцэтгэлд суурилсан санхүүжилт олгох
- Хөтөлбөр, арга хэмжээг боловсруулах, зориулалтын дагуу зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг сайжруулах.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Б.Гантулга танаа:

- Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нотлох баримтыг үндэслэн үнэлэх,
- Баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэх.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/39

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, төлбөрийн актыг хоёрдугаар, албан шаардлагыг гуравдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон аймгийн Засаг даргад хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитор (М.Номиндарь)-т даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

016010123

Рн2.Бичиг хэрэг 2024 оны тушаалын төсөл, төсөл

